

МХЗ-д суурилсан ҮХЦБ-ын эхний шатны үнэлгээний тайлан

Үнэлгээний удирдлага, зохион байгуулалт, арга зүй, аргачлал

Мянганы хөгжлийн зорилгод /МХЗ/ суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын /ҮХЦБ/ тайланг боловсруулахдаа орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг түүвэрлэн авах замаар хийсэн бөгөөд эдгээр зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолд заасан аргачлалын дагуу /Хавсралт 1/ хяналт шинжилгээ хийж үзээд хэрэгжилт 29,4 хувьтай байна гэж үзлээ.

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн ХШҮ-ний тасаг нь холбогдох бодлого хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын эхний шатны үнэлгээг 2006 оноос (МХЗ-д суурилсан ҮХЦБ-ын суурь он) 2010 оныг дуустал хугацааг хамруулан, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалаар хийж гүйцэтгэхийг хичээлээ.

Үнэлгээ нь мэдээлэл цуглуулах анхдагч хүснэгтээр (**Хавсралт 1**) ирүүлсэн мэдээлэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, холбогдох агентлаг, газар, хэлтсүүдийн жилийн эцсийн тайланд үндэслэсэн бөгөөд холбогдох байгууллагын зарим мэргэжилтнүүдтэй биечлэн уулзаж, үндсэн мэдээллийг баталгаажуулсан.

3.2.3 Боловсролын хөгжил

Удирдлага

Багшийн мэргэжил, аргазүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ.

Хэрэгжилтийн явц

Багшийн мэргэжил, арга зүй, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээнд нийт багшийн 2008 онд 67.8 хувь, 2009 онд 69.5 хувь тус тус хамрагдсан. ЕБС-ийн багш нараас удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо үргэлжилж байна.

Нийт 623 багш хамрагдсан ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын хөтөлбөр боловсруулах сургалтад “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3”¹-өөс 37.576 ам доллар, 2009-2010 оны хичээлийн жилд 6 настай хүүхдэд хичээл заах багш, тэдэнтэй ажиллах нийгмийн ажилтны мэргэшил дээшлүүлэх сургалтад “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрөөс 302.4 сая төгрөг зарцуулсан. “Техник мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл”², “ТЕМАСЕК” сангийн санхүүжилтээр техник мэргэжлийн сургуулийн багш нарын ур чадварыг дээшлүүлэх сургалтад нийт 100 гаруй багш нар хамрагджээ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ), түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага, түүний дотор хөдөөд байршилтай төрийн өмчийн 29 сургалтын байгууллагаас тодорхой болзол хангасан 512 багшид 1,3 тэрбум төгрөгийн /нэг багшид дунджаар 2,4-2,8 сая төгрөг/ тэтгэмж олгосон³.

¹ Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр

² Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр

³ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19,3-д “Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43,1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил дутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно” гэж заасан.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал			
	2006	2007	2008	2009
Жилд мэргэшил дээшлүүлсэн багшийн эзлэх хувь- 50%	71.1%	79.7%	67.8%	69.5%
Жил бүр багш нарын талаас илүү хувь нь мэргэжил дээшлүүлж байна.				
Боловсролын салбарын нийт багш нарт удирдлагаар мэргэшсэн боловсролын салбарын ажилтны эзлэх хувь	Боловсролын салбарт удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо бүрдээгүй, багш нарыг удирдах ажилтнаар томилон ажиллуулдаг хандлага хэвээр байна. Тодруулбал, 2008 онд нийт багш нарын 10.2%, 2009 онд 10.4% нь удирдах ажилтны эгнээнд шилжсэн байна.			
Мэргэшил дээшлүүлэхэд зарцуулсан нийт зардлын хэмжээ / 200 сая төгрөг / жилд/	2007	2008	2009	
	199.5 сая төг.	251 сая төг.	95 сая төг.	
Улсын төсвөөс багшийн мэргэжил дээшлүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ буурч байна.				
Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг бодит эрэлт хэрэгцээнд тулгуурлан нягтлан үзэх шаардлагатай.				

Багшийн мэргэжил, аргазүйн хөгжил, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай.

ҮХЦБ-ын Газар нутгийн алслагдалт, цаг уурын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох арга хэмжээ Засгийн газрын 95-р тогтоолд тусгагдаагүй байна. Өнөөгийн даган мөрдөж буй хуулийн дагуу орон нутагт ажиллаж буй багш нарт холбогдох нэмэгдлийг олгож байна.

Сургалтын хөтөлбөр

Боловсролын бүх түвшний стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.

Хэрэгжилтийн явц

ЕБС-ийн 12 жилийн сургуульд мөрдөх боловсролын стандартыг шинэчлэн боловсруулах ажлын бэлтгэлийг хангаж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагад бэлтгэх ерөнхий мэргэжлийн чиглэл, индекс⁴-ийг шинэчлэн батлав⁴.

“Техникийн боловсролын загвар” стандартын төсөл боловсруулсан. ХБНГУ-ын “ABU консалтинг” ХХК “Техник мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл”-ийн хүрээнд “Чадамжид суурилсан сургалт” дэд төслийг хэрэгжүүлж байна.

Англи хэлний багшийн стандартын анхны төсөл боловсруулаад байна.

Мянганы сорилтын сангийн “Үйлдвэр дээрх сургалтыг сайжруулах” дэд төслийн хүрээнд⁵ чадамжийн хөтөлбөр боловсруулсан.

⁴ БСНУ-ны сайдын 2010 оны 235 дугаар тушаал

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 212 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Төрийн бус өмчийн, гадаадын хөрөнгө оруулалттай, олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр бүхий “Орчлон”, “Улаанбаатар элит”, “Америк” зэрэг сургуулиудад 1102 сурагч сурч байна. Олон улсын Кембрижийн стандартаар хичээллэх сургууль 2010-2011 оны хичээлийн жилээс албан ёсоор сургалтын үйл ажиллагаагаа эхэлсэн.

ЕБС-д сурагчдын эрэлт хэрэгцээг харгалзсан, мэргэжлийн чиг баримжаа олгох, цаашид суралцах мэргэжлийн чиглэлийг сонгон судлах боломжийг бүрдүүлсэн нээлттэй сургалтын төлөвлөгөөг боловсруулан мөрдөж байна. Ахлах ангийн сурагчид 3-аас дээшгүй хичээлийг сонгон суралцаж байгаа нь тэдний судлах нийт хичээлийн 34.3 хувийг эзэлж байна. Бага ангийн нийт хичээлийн 3.0 хувь, дунд ангийн нийт хичээлийн 3.6 хувийг сонгон судлах хичээл эзэлж байна.

Бакалаврын боловсролын сургалтын зорилгод төгсөгч ”Англи хэлийг“ өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах чадвартай байх⁶ гэж тусгаж, бакалаврын мэргэжлийн бус ангид англи хэлийг заавал үзэх хичээл болгож, агуулгын багтаамжийн доод хэмжээг 8 багц байхаар тогтоосон.

Дээд боловсролын шинэчлэлийн 2010-2021 оны зураглал⁷-ын дагуу дээд боловсролын засаглал, менежмент, хүний нөөц, сургалтын хөтөлбөрийн байдалд 2010 онд үнэлгээ хийгдсэн.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал						
Стандартын шалгуур хангасан хөтөлбөрийн хувь - 30%	Боловсролын бүх түвшний стандарт, түүнийг хангасан хөтөлбөрийг тодорхойлох боломжгүй тул шалгуур үзүүлэлтийг дахин нягтлах шаардлагатай.						
Цогц хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлсэн хөтөлбөрийн хувь- 80%	Шинэчлэн өөрчилж буй боловсролын агуулгад ҮХЦБ-д дурдсан шаардлагын дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэх шаардлагатай.						
Улаанбаатар хотод байршилтай “Туршилтын бааз, лаборатори” сургуулийн тоо- 6, аймаг бүрт 1	Энэ талаар мэдээлэл байхгүй. Үйл ажиллагааг эхлэх шаардлагатай.						
ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд монгол хэл, бичгийн хичээлийн цагийн эзлэх хувь- 18.5% ⁸	<table border="1"> <thead> <tr> <th>2007</th> <th>2008</th> <th>2009</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>18.5</td> <td>18.9</td> <td>20.2</td> </tr> </tbody> </table> <p>Монгол хэл, бичгийн хичээлийн ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд эзлэх хувь жил дараалан нэмэгдсээр байна. Цаашид зорилтот түвшинг шинэчлэх шаардлагатай.</p>	2007	2008	2009	18.5	18.9	20.2
2007	2008	2009					
18.5	18.9	20.2					
Англи хэлний анхан шатны боловсролтой иргэдийн эзлэх хувь- 30%	Мэдээлэл байхгүй. Шалгуур үзүүлэлт бодитой бус.						
Их, дээд сургууль төгсгөгчдийн англи хэлний боловсролын дундаж түвшин Тофелийн дундаж оноо 500	Их, дээд сургуулийн түвшинд албан ёсоор шаардлага тавигдаж эхэлсэн байна. Англи хэлний хичээлээр олгох мэдлэгийн түвшинг “Англи хэлний олон улсын дундаж түвшин “Intermediate” –тэй дүйцэхүйц мэдлэг чадвар олгоно гэж тодорхойлсон.						
Боловсрол судлалын санхүүжилтийн хэмжээ	Мэдээлэл байхгүй, хөрөнгө хуваарилагдаагүй.						

ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх үйл ажиллагаа эрчимтэй явагдаж, сургалтын олон хувилбарт төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Гэвч ЕБС-ийн 12 жилийн сургалтын хөтөлбөрийн стандарт батлагдаагүй байхад 2008 оноос 6 настнуудыг сургуульд элсүүлсэн нь сургалтын агуулга чанарт шууд нөлөөлөхийг анхаарах хэрэгтэй.

⁶ Англи хэлний хичээлээр олгох мэдлэгийн түвшинг “Англи хэлний олон улсын дундаж түвшин “Intermediate” –тэй дүйцэхүйц мэдлэг чадвар олгоно гэж тодорхойлж өгсөн.

⁷ Засгийн газрын- хуралдааны 2010 оны 7 сарын 7-ны 40-р тэмдэглэл

⁸ Засгийн газрын 95 тогтоолын хавсралтын шалгуур үзүүлэлтийг хянан үзэж, 2015 онд хүрэх түвшинг шинэчлэн тогтоох саналтай байна.

Боловсролын бүх түвшинд мөрдөх стандарт, түүний шалгуур үзүүлэлтийг тогтоох ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

ҮХЦБ-ын эхний шатны зорилтод хүрэхийн тулд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг дахин нарийвчлан судалж, тогтоох нь зүйтэй.

3.2.4 Соёлын хөгжил

Удирдлага

Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжилтийн явц

Хэнтий аймгийн соёлын салбарт 2010 оны байдлаар 25 соёл, урлагийн байгууллагад 186 хүн ажиллаж байгаагийн 68% нь мэргэжлийн ажиллагсад байна.

Хөдөөгийн хүн амд хүргэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх, үндэсний уламжлалт болон орчин үеийн соёл, урлагийг дэмжин сурталчлах, соёл, урлагийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх:

2010 онд аймгийн хэмжээнд 700 гаруй удаа урлагийн тоглолт хийж давхардсан тоогоор 230202 иргэдэд үйлчилж, соёлын урлагийн материаллаг баазыг дээшлүүлэхэд Тогтвортой амьжиргаа-2 төсөл, Дэлхийн зөн олон улсын байгууллагын хандив тусламжаар 12 сумын соёлын төвийн материаллаг бааз техникийн шинэчлэлтэнд 61,3 сая төгрөг зарцууллаа.

Батширээт, Биндэр, Жаргалтхаан, Бэрх, Дархан, Галшар, Мөрөн, Дадал, Хэрлэн, Цэнхэрмандал, Баян-овоо, Дэлгэрхаан зэрэг 17 сумын соёлын төвүүдэд төсөл хөтөлбөр болон УИХ-ын гишүүн, Нутгийн зөвлөл, ард иргэдийн хандиваар 181,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс Тогтвортой амьжиргаа-2 төслийн хөрөнгөөр 2 сумын соёлын төвийн барилгад 25,3 сая төгрөгийн их засвар, 12 соёлын төвийн техник тоног төхөөрөмж шинэчлэхэд 61,3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Түүх соёлын дурсгалт зүйл, музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэхэд хяналт тавих, иргэдийн оролцоог идэвхжүүлэн, сурталчилгааг нэмэгдүүлэх чиглэлээр

2010 онд 800ш үзмэр бүтээлийн эрдэм шинжилгээний тодорхойлолтыг илгээхээс нийт 810ш үзмэр бүтээлийн тодорхойлолтыг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт 1614ш үзмэрийн бүртгэл Соёлын өвийн төвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хүргээд байна.

2009 онд илгээсэн 804ш үзмэрийн тодорхойлолтыг CD-д буулган архивлаж архив үүсгэн, аймгийн 17 сумдын Түүх,соёлын үл хөдлөх дурсгал, Соёлын биет өв, Соёлын биет бус өв тээгчдийн тайлан, судалгааг нэгтгэн аймгийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх ажил хийгдэж байна.

Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа үзмэр бүтээлүүдээс Соёлын өвийн төвд илгээгдсэн үзмэрийн гэрэл зургийг /16ш/ CD-д буулган Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хүргүүлсэн бөгөөд байгууллагын Бүртгэл мэдээллийн санд нийт 17ш CD-д цахим архив үүсгэжээ.

Түүх, Соёлын дурсгалыг сэргээн засварлах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сэцэн ханы ордон музей \Угсаатны зүйн музей\ -г сэргээн засварлах тендерт “Архитектур нэгдэл” байгууллага шалгарч, энэ онд багтаан зурагжилтын ажил хийхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

Соёлын ажилтан уран бүтээлчдийг төв орон нутгийн мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамруулах, театр чуулгын зарим багш уран бүтээлчдийг орон нутгийн зардлаар СУИС-д гэрээгээр бэлтгэж, орон нутагт ажиллуулах асуудлыг судалж хэрэгжүүлэх:

Сумын соёлын төвийн үйл ажиллагааг мэргэжлийн боловсон хүчнээр хангахад гол анхаарлаа хандуулсны үр дүнд 26 соёлын ажилтанг Соёлын дээд сургуулийн эчнээ ангид суралцаж, мэргэжлийн боловсон хүчний хангалт 68,3%-д хүрч өмнөх оноос 12%-иар нэмэгдсэн.

Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын мэргэжлийн багш нарыг түшиглэн 2 удаагийн сургалтанд соёлын төвийн 45 дуу хөгжим, бүжгийн багш нарыг орон нутагтаа мэргэжил дээшлүүлсэн.

Соёл Урлагийн байгууллагуудын ажилтныг эчнээ, мэргэжлийн төвлөрсөн сургалт болон орон нутагт мэргэшүүлэх сургалтанд 95 соёлын ажилтныг хамруулснаар нийт ажиллагсдын 70%-ийг хамруулсан гэсэн үзүүлэлт гарч байна.

Орон нутагт соёл, урлагийн боловсон хүчнийг мэргэжшүүлэх сургалтанд хамруулсан хэдий ч мэргэжлийн боловсон хүчний хангалт дутагдалтай хэвээр байгаа нь ажиллах орчин нөхцөл бүрдээгүй, цалин бага / адилхан Соёлын дээд сургуулийг төгсөөд ЕБС-д ажиллахад цалингийн шатлал дээгүүр байдаг/ эдийн засгийн урамшуулал, хөшүүрэг байхгүй байгаатай холбоотой байна.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал			
	2007	2008	2009	2010
Соёл, урлагийн санхүүжилтэд улсын төсвийн болон төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийгдсэн байдал /сая.төг/	436,4	697,4	753,4	61,3
	2010 онд “Тогтвортой амьжиргаа -2” , Дэлхийн зөн олон улсын байгууллагаас барилгын их засвар, техник хэрэгслийн шиэнчлэлд 61,3 сая.төг зарцуулсан.			
Нийт ажилтанд мэргэжилтэй ажилтны эзлэх хувь	36,4	37,5	56,3	68,3
	Салбарын мэргэжилтэй ажилтны тооны өсөлт удаашралтай байна.			
Жилд мэргэшил дээшлүүлсэн ажилтны хувь-25%	30	35	50	70
Төсвийн зардлаас уран бүтээл хийх зардалд зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/	22,0		17,9	

Соёл, урлагийн салбарт тодорхой төлөвлөгөөний дагуу мэргэжлийн тодорхой чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, тэднийг хөдөө, орон нутагт тогтвор сууршилтай ажиллуулахад анхаарах шаардлагатай.

Томоохон бүтээл туурвилыг санхүүжүүлэх үндэсний хэмжээний хөгжлийн сан бүрдээгүй байна.

Үйлчилгээ

Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана.

Хэрэгжилтийн явц

“Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд хадгалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсний үр дүнд соёлын өвийг бүртгэхэд шаардлагатай техник хэрэгслээр хангасан. Музейн сан хөмрөгийн 2007-2008 онд явуулсан тооллогын дүнд улс, аймгийн музейн үзмэрийг тоолж, 2010 оны байдлаар 15052 үзмэр бүртгэгдсэн байна.

Монгол Улсын биет бус соёлын өвийн төлөөллийн үндэсний бүртгэл, Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлийг батлуулж⁹, холбогдох мэргэжлийн байгууллагуудыг техник хэрэгслээр хангах арга хэмжээ авсан. Биет бус соёлын өвийг өвлөн тээгчийн тоо 2009 оны байдлаар 90 байна.

Үндэсний уламжлалт соёлыг хөгжүүлэхтэй холбогдуулан “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монголын уламжлалт бий, биелгээ” хөтөлбөр боловсруулан, олон талт арга хэмжээг зохион байгуулж байна. “Морин хуур, уртын дуу” хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийн уртын дууны онцлогийг дэлгэн хөгжүүлэх, авьяастныг тодруулах, цаашид уламжлалт хөг, аялгууг уламжлан хөгжүүлэх зорилгоор бүсийн уртын дууны наадам зохион байгуулсан. Хүүхдэд зориулсан урлагийг дэмжих Үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулсан. “Музейн стандарт” MNS-5634:2006, “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандарт MNS-5742:2007-г боловсруулан мөрдөж байна.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал			
	2007	2008	2009	2010
Монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг цэгцлэхэд зарцуулсан хөрөнгө.	0	0	0	0
Улсын нэгдсэн бүртгэлд авсан түүх соёлын хөдлөх, үл хөдлөх дурсгалын тоо	133	350	393	422
Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд явуулсан үзмэрийн тоо	400	804	810	

2010 оны байдлаар музейн 15052, үл хөдлөх 332 дурсгалт зүйлсийг бүртгэж

Аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт 1614ш үзмэрийн бүртгэлийг СӨТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хүргэгдсэн.

Монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалахад төрөөс анхаарал илүүтэй тавьж, хөрөнгө зарцуулах шаардлагатай байна. Зарцуулсан хөрөнгөөс илүүтэй хадгалан хамгаалж, сэргээн засварлаж, нийтийн хүртээл болгосон өвийн тоо илүү чухал болов уу.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг сэргээн засварлахад хөрөнгө зарцуулахыг санал болгож байна.

⁹ БСШУ-ны сайдын 2009 оны 293 дугаар тушаалаар баталсан.

3.2.6. Нийгмийн хамгаалал

Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Хэрэгжилтийн явц

Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэх чиглэлээр:

Нийгмийн халамжийн тухай” хуульд 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар хараа хяналтгүй, гэр бүлийн орчинд амьдарч чадахгүй байгаа хүүхдийг гэр бүлдээ авч асрамжлан, халамжилж байгаа өрхөд сар бүр тэтгэмж олгох болсон. Мөн бүтэн өнчин өссөн 18 насанд хүрсэн хүүхдэд орон гэртэй болоход нь зориулж нэг удаа дэмжлэг үзүүлж, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, байнгын асаргаатай иргэдэд тэтгэмж, тусламж үзүүлж байна

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”¹⁰-ын дагуу өрхийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл цуглуулах ажлыг Хэнтий аймгийн хэмжээнд эхлүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна. Уг мэдээллийн баазыг үндэслэн ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэн, ажлын байртай болгох, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх юм.

Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай” хууль батлагдаж гарсантай холбогдуулан Хэнтий аймагт “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн нэгдүгээр үе шатны хүрээнд аймгийн Засаг даргын 2006 оны 06 дугаар сарын 23-ны 163 тоот захирамжаар Нийгмийн бодлого зохицуулалтын хэлтсийн даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр комисс томилон баталсан.

Аймгийн нийгмийн зөвшлийг хангах 3 талт гэрээг 2010 оны 3 дугаар сарын 19-ны өдөр хэлэлцэн баталж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулан ажил олгогч, үйлдвэрчин, төрийн байгууллагийн төлөөллийг оролцуулж 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн, дүрмийг баталсан нь иргэний нийгмийн хамгааллын болон хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, түншлэн ажиллах боломж нөхцлийг бүрдүүлж өгсөн.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хуульд Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хороогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тогтоох болсон.

Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр:

Хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Үйлдвэр дээрх сургалтын хөтөлбөр”¹¹ “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”¹², “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл, “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн орон нутгийн үйл ажиллагааны хөтөлбөр” “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр”¹³ хэрэгжиж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүд, тухайн аж ахуйн нэгжид ажиллаж байгаа ч мэргэжил ур чадвараа дээшлүүлэх шаардлагатай иргэдийг ажил олгогчид үйлдвэрлэл дээрээ 45 хоног сургаж ажилд зуучилж үндсэн ажилтан болгох хүсэлтээ иргэдийг компаниудыг сонгон шалгаруулж авч ажилласан. Дээрх хөтөлбөрт 2010 онд Хэнтий аймгийн хэмжээнд 33.6 сая төгрөгийг зарцуулсан. 2010 онд ногоочин, гар урлал-бэлэг дурсгал, оёдол, цахилгаан гагнуур, гоо сайхан, цэцэрлэгийн туслах багш, хүнд машин механизмын операторчин, тогооч, барилгын засал чимэглэл, барилгын мужаан зэрэг сургалтуудыг МСҮТ, Абука, Арука, Мастер, Шинэ хөгжлийн гарц зэрэг сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулж 295 иргэн хамрагдаж 33,6 сая төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Сургалтанд хамрагдсан иргэдийн 73% буюу 215 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжих, улмаар ажилтай болгох зорилгоор ХБИ-ээс санаачлан боловсруулсан төслийг сонгон шалгаруулж, 2010 онд 5 төсөлд 10 сая төгрөгийн ХХҮХ-ээс, ХЭДС-аас олгосон. Төсөл шалгаруулах журамд хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө эсхүл гэр бүлийн гишүүн нь төслөө хэрэгжүүлэх саналаа гаргахаар заасан нь тухайн өрхийн амьжиргааг дээшлүүлэх, тогтвортой орлого бүхий аж ахуй эрхэлж, ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлж буй хөшүүрэг юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох зээлийн хүү нөхөн төлөх журам”¹⁴-ын дагуу банкуудаар дамжуулан бичил зээлийн үйлчилгээнд Хадгаламж болон Хаан банкаар дамжуулан 375 иргэнд 342,9 сая төгрөгийн зээлийг олгосноор 245 ажлын байраар хангагдсан байна.

Ажлын байрны хомсдол, ахимаг насны иргэдийн эзэмшсэн мэргэжил, ур чадвар зах зээлийн шинэ эрэлтэд нийцэхгүй байх, хөдөлмөрийн зах зээлд шилжиж байгаа залуучууд мэргэжилгүй байгаа болон эдийн засаг, нийгмийн бусад шалтгаанаар олон хүн ажилгүй байна. Иймээс дээр дурьдсан онцлог хэрэгцээ бүхий иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар амьжиргааг нь сайжруулж, ядуурлаас гаргахад хувь нэмэр болохуйц дэмжлэг туслалцааг олон нийтийн оролцоо, орон нутгийн санаачилгад тулгуурлан төсөл, нэмэлт үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулах зорилгоор “Ажил олоход бэрхшээлтэй бүлгийн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого бариж ажилласан.

УИХ-д өргөн барьсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд аж ахуй эрхлэлтийн сургалт, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлж, ХЭДС-аас зээлийн эрсдлийн болон баталгааны сан байгуулах зэрэг шат дараалсан арга хэмжээгээр дэмжих, ХЭДС-гаас олгож байгаа жижиг зээлийн зориулалтыг тодорхой болгох, зээлийн

хугацааг нэмэгдүүлэхээр тусгасан нь байнгын ажлын байрыг өргөжүүлэх, иргэдийн орлогын эх үүсвэрийн тогтвортой байдал болон хэмжээ нь нэмэгдэхэд нааштай үр нөлөө үзүүлэх юм.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал				
Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг бүрдүүлсэн байна.	Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санд Хэнтий аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар 23.8 мянган иргэн бүртгэлтэй байна.				
Хөдөөгийн хүн амд зориулсан нийгмийн явуулын үйлчилгээ явуулах нэгжийн тоо, хамрагдсан иргэдийн тоо	Төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагатай гэрээ хийх замаар “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 26 дугаар зүйлд заасан гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ, сэргээн засах зэрэг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Гэрийн асрамж, халамжийн явуулын үйлчилгээний зардлын жишиг үнэ, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар зэргийг ХХҮГ-ын даргын тушаалаар батлан мөрдүүлэв. Хөдөлмөр эрхэлж ,орлогын эх үүсвэртэй болоход 41 хүнд 12079,0 төгрөг, сэргээн засах үйлчилгээнд 20 хүнд 544,0, түр байршуулан асрахад 18 хүнд 750,0, асаргаа үйлчилгээний сургалтанд 40 иргэнд 4326,0 төгрөгийн бүгд 158 хүнд 17699,0 төгрөгийн зардаргаргасан байна.ОНОТХҮ-г ирнэн, ААН, ТББ-аар гэрээ байгуулан гүйцэтгүүллээ.				
Чадамжид суурилсан ур чадварыг хөгжүүлэх сургалтын тогтолцоог нэвтрүүлсэн байна	2010 онд ногоочин, гар урлал-бэлэг дурсгал, оёдол, цахилгаан гагнуур, гоо сайхан, цэцэрлэгийн туслах багш, хүнд машин механизмын операторчин, тогооч, барилгын засал чимэглэл, барилгын мужаан зэрэг сургалтуудыг МСҮТ, Абука, Арука, Мастер, Шинэ хөгжлийн гарц зэрэг сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулж 295 иргэн хамрагдаж 33,6 сая төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Сургалтанд хамрагдсан иргэдийн 73% буюу 215 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдаад байна.				
Гадаадад ажиллах хүч гаргах, авах бодлого, эрх зүйн орчинг шинэчилсэн байна	Өлзийт, Баянхутаг, Бор-Өндөр, Цэнхэрмандал, Галшар зэрэг сум,тосгонд зөвшөөрөлтэй 8 гадаадын иргэн ажиллаж байна.				
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчны талаархи ОУХБ-ын конвенциудад нэгдэн орж, үндэсний хууль тогтоомжоо тэдгээрт нийцүүлсэн байна.	ОУХБ-ын Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн байцаан шалгах газрын тухай 81 дүгээр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай 161 дүгээр конвенцийг Монгол Улс соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан танилцуулга, судалгааг 2008 онд УИХ-ын байнгын хороонд хүргүүлсэн бөгөөд шаардлагатай нэмэлт тайлбарыг гаргаж, УИХ-ын холбогдох байнгын хороонд 2010 онд дахин хүргүүлсэн.				
Ажиллах хүчний оролцооны түвшин	2006	2007	2008	2009	2010

	69.9	70.8	74.0	75.0	75.0
	Ажиллах хүчний оролцооны түвшин 2008 онд 74,0 хувьтай байсан бол 2010 онд 77,0 хувьд хүрч 3,0 пунктээр өссөн байна.				
Эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд	“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, хүрээнд 2009-2010 онд давхардсан тоогоор 561 малчин өрхийг хамруулан хэрэгжүүлж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн “хүрээнд 2010 онд нийт 5 төсөлд 10,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.				
Гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн монгол иргэдийн хөдөлмөр болон бизнес эрхлэлтийг дэмжих эрх зүйн зохицуулалт бий болсон, хөтөлбөр хэрэгжсэн байна.	Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийг эх орныхоо бүтээн байгуулалтад оролцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Зөгийн үүр” хөтөлбөр -ийг хэрэгжүүлж байна.				
Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэлийн тогтолцоо бүрдсэн байна	Хөдөлмөрийн төв биржийн Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийг хамруулсан. “Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн улсын үзлэг”-ийг 2009 онд 686 албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамруулан зохион байгууллаа. / уул уурхайд байсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо ороогүй болно.				
Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан нийгмийн даатгалын тогтолцоо бүрдүүлсэн хууль батлагдан гарсан байна	Одоогийн тэтгэврийн даатгал хөдөлмөр эрхлэлтийн онцлогт нь нийцэхгүй байгаа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулж тусгай тогтолцоо нэвтрүүлэхээр боловсруулсан хуулийн төсөлд Дэлхийн банкны зөвлөх багаас зөвлөгөө авч сайжруулж байна.				
Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо буурсан байна. /Албан салбарт шилжсэн байна/	Мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2011 оны 4 сараас эхлэн шинэчлэн хийгдэнэ.				
Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эцэг, эх, гэр бүлийн гишүүдийг орлоготой болгох, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн байна	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн “Хөдөлмөр эрхэлж буй болон эрхлэх эрсдэлтэй хүүхдэд чиглэсэн шууд туслалцаа, үйлчилгээний төсөл”-ийн хүрээнд 2007-2010 оны хооронд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн эцэг эх болон өрхийн гишүүдээс 7338 хүнийг мэргэжлийн болон бизнесийн, амьдрах ухаан болон бусад сургалтанд хамруулж, 412 хүнд жижиг зээл, орлого нэмэгдүүлэх тусламж, нэн ядуу 2058 өрхөд буцалтгүй тусламж үзүүлсэн байна.				

Байнгын асрамж, асаргаа шаардлагатай хэвтрийн болон ганц бие ахмад настанд гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг¹⁵ ТББ, бүлэглэл, хувь хүмүүстэй гэрээ байгуулан хүргэж байна. Гэхдээ шаардлага хангасан үйлчилгээ эрхлэгчид цөөн байгаагаас үйлчилгээний хүрээ бага (цөөхөн баг хороо хамрагдаж) байна. Иймд үйлчилгээ эрхлэгч ТББ хувь хүмүүсийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн мэргэжилтэй ажилчин бэлтгэх, ур чадварт суурилсан тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна.

Хөдөлмөрийн зах зээлийг тэлж, ажиллах хүчнийг шингээх үүднээс хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуй, боловсруулах үйлдвэрүүдийг хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлогоор дэмжих хэрэгтэй байна.

Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих шаардлагатай байна.

4.5 Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

Хүүхдийн эндэгдлийг бууруулах

Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ.

Хэрэгжилтийн явц

ДЗОУБ-тай хамтран “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглэх заавар, зөвлөмж хэмжээ” сэдвээр танилцуулах сургалтыг 2010 оны 03 сарын 15, 05 сарын 08-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж сум өрхийн эмнэлгийн 65 эмч мэргэжилтнүүдийг хамруулж, ЭМГ-ын даргын тушаалаар бүх сумдад 06-24 сартай хүүхдүүдэд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг хуваарилан олгож хэрэглээнд хяналт тавин ажиллаж байна.

Хэрлэн сумын хэмжээнд Санбүрд ОСТВ-ээр ард иргэдэд зориулсан мэдээлэлийг 3 удаа явуулсан. Мөн Өмнөдэлгэр, Биндэр сумдын хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдийг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Сумдын эмнэлгүүд хүүхдийн хоол тэжээл, чийрэгжүүлэлтийн сувилалыг ажиллуулж нийт 787 хүүхдийг хамруулсан. Энэ арга хэмжээг сүүлийн жилүүдэд Өмнөдэлгэр, Гурванбаян, Баян-Овоо, Баянмөнх, Бэрх, Биндэр, Жаргалтхаан, Баян-Адрага, Батширээт сумын эмнэлгүүд тогтмол сайн ажиллуулж хэвшүүлээд байна. ЭМГ-ын хоолны сургалтын өрөөнд албан байгууллагын ажилчдад зөв зохистой хооллолтын сургалт явуулж, өөрсдөөр нь хоолны цэс зохиолгон хоол хийлгэж дадлагажуулсан.Өсвөр үеийнхэний биеийн жингийн индекс тодорхойлж зөв хооллолтын зөвлөгөө өгч гарын материал олгосон.

“Зөв зохистой хооллолт” сэдвээр нийт 3 албан байгууллагын 80 гаруй хүнд сургалт явуулж, “Эрчүүдээ хайрлая” сэдэвт ажлын хүрээнд 100 гаруй хүнд биеийн жингийн индекс тодорхойлж зөв зохистой хооллолтын талаар зөвлөгөө өгсөн. 2010 оны 10 сараас 4 дүгээр сарын өсөлт хөгжлийн мэдээлэлд Д аминдэмжүүлэлтийн мэдээг сум өрхүүдээс нэгтгэн авч мэдээ тайланд хяналт тавьж ажилладаг.

Сумдын Засаг даргын үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд эх, нялхсын эндэгдлийн түвшинг тусгаж өгснөөр орон нутгийн удирдлагын зүгээс эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн чухал арга хэмжээ болжээ.

¹⁵ Нийгмийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх шинэ хэлбэрийг 2006 оноос эхлүүлэн хэрэгжүүлж, 2008 оноос “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам”-ыг мөрдөж байна.

Хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор хүүхэд, нярайн 3 эмчийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан.

Аймгийн хэмжээнд хүүхэд нярайн чиглэлээр 4 удаа 128 цагийн сургалтыг зохион байгуулж, сум, өрхийн эмч нарыг хамруулсан.

ЭМСайдын 2008 оны “Нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тухай” 02 тоот тушаалын хэргэжилтийг ханган ажиллаж эмгэг төрөлтийн тохиолдол бүрт нярайн эмчийг оролцуулж, сумдад яаралтай журмаар хийгдэж байгаа кесарево хагалгаанд явуулж байна. Өрхийн эмнэлгүүд төрөх тасгаас гарч буй нярайд өдөр бүр хүлээн авч эргэлтийг сайдын тушаалын дагуу хийж байна. Нярайн болон хүүхдийн эмч нар өрх сумдын эмч нартай байнгын ажил төрлийн холбоотой ажиллаж мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллаж ирлээ. Өрхийн эмнэлгүүдэд хүүхдийн эмч нар улирал тутамд үзлэг хийж мэргэжлийн зөвлөгөө өгч байна.

“Нярайн сэхээн амьдруулалт” сэдвээр сумдын 35 эмч, эх баригч нарт сургалт явуулсан.ЭМГ-ын даргын тушаалаар нярайн сэхээн амьдруулагч, салиа соруулагчийг бүх сумдад хувиарлан, сумын эмч нарыг Нэгдсэн эмнэлгийн төрөх, дотор, хүүхдийн тасагт хуваарийн дагуу ажиллуулж дадлагажих сургалтанд хамруулан хийсэн ажлын тайланг хамгаалуулж тестээр шалгалт авсан нь үр дүнтэй ажил боллоо.Нялхасын эндэгдлийг ЭМГ-ын зөвлөлөөр хэлэлцүүлж хэвшүүлсэн.

ХӨЦМ-ийн шинэчилсэн программын дагуу үзлэгийн маягт хөтлөх аргачлалыг зааж үзлэгийн маягтын загварыг сум өрхийн эмнэлгүүдэд олгосон. Сум өрхийн эмнэлгээс ирүүлж буй сар бүрийн мэдээг /хүүхдийн өсөлт хөгжил, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн мэдээ, “А” болон “Д” аминдэм/ хянаж зөвлөгөө өгч ажилласан.

Сумдыг хүүхдийн эмчтэй болгох бодлогоор 5 эмчийг хүүхдийн мэргэжил олгох, төв хөдөөгийн 8 эмчийг мэргэжил дээшлүүлэх дамжаанд суралцуулаад байна.

ДЗОУБ-ын ХХНХХөтөлбөр, НҮЭМ-ийн хөтөлбөр, ХӨЦМ, НҮБХСангаас хувиарлагдан ирсэн Д аминдэм, төмрийн бэлдмэлийг зорилтот бүлгийн хүмүүст уулган өрх сумын эмнэлгүүдэд цус багадаалтын түвшинг гемоглобины тестээр хянаж урьдчилан сэргийлэх болон эмчилгээний тунг сонгон хэрэглэж үр дүнг тооцон үнэлгээ өгч ажилласан.

Үр дүн:

2015 онд хүрэх зорилт		Өнөөгийн байдал ¹⁶				
		2006	2007	2008	2009	2010
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 21 (1000 амьд төрөлт тутамд)	Улс	23.2	21.7	23.2	23.6	26.8
	Хэнтий		20,7	37,3	31,7	28,1
Нялхсын эндэгдлийн түвшин 15 (1000 амьд төрөлт тутамд)	Улс	19.1	17.6	19.4	20.2	21.2
	Хэнтий		17,6	27,6	29,2	19,5

2010 оны 12 сарын байдлаар:

Аймгийн хэмжээнд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2010 онд 19,5 промил, 2009 оны мөн үетэй харьцуулахад 29.2 промил байгаа нь 9,7 промилиэр, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 31,7 промил байсан бол 2010 онд 28.1 болж 3,6 промилиэр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Дүгнэлт: Дээрхи арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төв хөдөөгийн эмч нарын хүүхдэд үзүүлэх тусламжийн чанарт ахиц гарч, өвчлөл эндэгдэл буурч байна.

Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн цус багадалт 18.2%-иар буурч, бага насны хүүхдийн цус багадалт 12%-иар, Д аминдэмийн дутал 10%-иар буурсан. Эхийн эндэгдэл буурч,улаан бурхны эсрэг вакцинжуулалтанд хамрагдсан 1 хүртлэх насны хүүхдийн хувь өсч, эмнэлгийн ажилтан эх барьсан төрөлтийн тоо, төрөөд 1 цагийн дотор ангир уургаа амласан хүүхдийн хувь өссөн байна.

Тураалтай, туранхай, өсөлтийн хоцрогдолтой 5 хүртлэх насны хүүхдийн хувь буурч, 5 -17 насны хүүхдийн өвчлөл, насанд хүрээгүй охидын төрөлтийн хувь тус тус буурсан байна.

Эхийн эрүүл мэндийг сайжруулах

Эх нялхсыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох

Хэрэгжилтийн явц

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний 3 дахь (2007-2011) хөтөлбөр, Эхийн эндэгдлийг бууруулах стратеги (2006-2010)-ийг хэрэгжүүлж байна. “Эх, нярайн-Эрүүл мэнд 2011-2015 стратеги”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. НҮБХСангаас үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор алсын зайн оношлогоог нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэхээр судалгааны ажил хийгдэж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт нярайн сэхээний өрөөг тохижуулан эх, нярайн тусламжид нэн шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. ЭМЯ, НҮБ ХАС - НҮЭМ (MNG4R31C) төслийн санхүүжилтээр аймгийн нэгдсэн эмнэлэгт 19571.8 төгрөгийн өртөг бүхий ЭХО аппаратаар хангагдлаа.

2010 оны байдлаар бүх сумын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг эхчүүдийн амрах байртай. Тогтвортой амьжиргаа-2 төслөөр 3,8 сая төрөгийн өртөгтэйгээр Баянхутаг сумын эхийн амрах байрны засвар хийгдсэн.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт		Өнөөгийн байдал ¹⁷				
		2006	2007	2008	2009	2010*
НҮЭМ-ийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийн түвшин 50 (100.000 амьд төрөлт тутамд)	Улс	67.2	88.3	48.6	81.4	44.7
	Хэнтий	88,9	76,3	138,4	126,9	0

Манай аймаг **2010 оны байдлаар:** Эхийн эндэгдэл гараагүй боловч сүүлийн 10 жилд эхийн эндэгдэл тасраагүй. Төрөлтийн түвшин 2007,2008,2009 онуудад нэмэгдэж, 2010 онд буурсан байна.

Жирэмсний эхний 3 сардаа эмнэлгийн хяналтад орсон жирэмсэн эхчүүдийн хувь 76,5 байгаа нь 2009 оноос бага зэрэг буурч байна

*Хүснэгт 3.2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, сонгосон үзүүлэлтээр*¹⁸

Сонгосон үзүүлэлт		Өнөөгийн байдал ¹⁹				
		2006	2007	2008	2009	2010*
Жирэмсний эхний 3 сардаа эмнэлгийн хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь	Улс	81,5	84,0	83,7	83,2	
	Хэнтий	82,1	84,2	86,0	83,0	77,0
Жирэмслэлтээс сэргийлэх арга хэмжээний хэрэглээний түвшин /15-49 насны эмэгтэйчүүд/	Улс	50,8	52,8	52,6	53,2	
	Хэнтий	49,6	45,5	45,4	48,4	47,3
Үр хөндөлт /1000 амьд төрөлтөнд/	Улс	265,8	283,5	168,9	183,2	
	Хэнтий	559,1	342,7	318,3	293,3	199,6
Үр зулбалт	Улс	2204	2871	2848	3215	
	Хэнтий	71	85	95	70	91

Эхийн эрүүл мэндийн байдлаас улбаатай үр зулбалт 2006 онд 71, 2007 онд 85, 2008 онд 95, 2009 онд 70 бүртгэгдэж байсан бол 2010 онд 91 болж өсчээ. Гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, жирэмслэхээс сэргийлэх аргын хэрэглээ нэмэгдэж байгаа ч 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт 2006 онд 559.1, 2007 онд 342.7, 2008 онд 318.3, 2009 онд 293.3, 2010 онд 199,6 байгаа нь өмнөх онуудаас тогтвортой буурсан үр дүн харагдаж байна. Өнгөрсөн оноос 93,7 промилиэр буурсан байна.

Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах.

БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэтэй тэмцэх чадвартай болгох

Хэрэгжилтийн явц

“ХДХВ/ДОХ-оос сэргийлэх Үндэсний стратеги”, “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг оролцогч талуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд 18 баар, зочид буудал цэнгээний газруудтай гэрээ хийж ажиллан Цагдаагийн газар, МХГ, ЭМГазар хамтран тэдний үйл ажиллагааг 2 удаа хянаж бэлгэвчийн түгээлт, хэрэглээг шалгаж зөвлөгөө өгч ажилласан. Нийт 38500 ш бэлгэвчийг ЭМГазар, СДЗШТөв тараасан байна Дүйцүүлэх албаны 30 цэрэг, улсын цэрэг татлагын 22 сумын 1300 орчим залуучуудад урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт хийв. Чингэлтэй дүүргийн ЭМНэгдлийн “Сэтгэл амар” төвийн нийгмийн ажилтан болон тандалт судалгааны багийнхантай хамтран Хэрлэн сумын зочид буудал, зоогийн газруудад тандалт хийж зорилтот олон

нийт байдгийг илрүүлсэн ба МСҮТөвийн сурагчдад мэдээлэл өгч, эрсдэлт бүлгийн байж болохуйц 20-иод эмэгтэйтэй уулзан ярилцаж байршлыг тогтоон сургалтын урилга өгч, 15 зорилтот олон нийтийг илрүүлж “Ногоон карт”-жуулан сайн дурын үндсэн дээр шинжилгээнд хамруулан эрсдэлт зан үйлээс татгалзах, ЭМБ-уудтай хамтран ажиллах талаар санал солилцож, шинжилгээнд хамруулсан. Үүнээс заг хүйтэн 2, трихомониаз-2, тэмбүү-3-ийг илрүүлэн эмчиллээ.

Нарийн мэргэжлийн эмч нарын баг хөдөөгийн хүн амд нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж 21 сумдаар явж нийт 746 хүнд үзлэг шинжилгээ хийж тэмбүү-4, заг хүйтэн-5, трихомониаз-18-ыг илрүүлж хавьтлыг хамт эмчиллээ. ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх “100% БХХөтөлбөр”-ийн хүрээнд, Хэрлэн сумын ЗДТГазар, Цагдаагийн газрын гаргасан биеэ үнэлэгч байж болохуйц эмэгтэйчүүдийн судалгааг үндэслэн хамтран ажилласан. ХӨСҮТ-ийн ТСАлбаны мэрэгжилтэнүүдтэй хамтран Дадал, Батноров, Норовлин сумын БЗДХ-ын хам шинжийн оношлогоо эмчилгээний байдалд хяналт үнэлгээ хийж ажилласан.

СДЗШТөвд: Сайн дураараа үйлчлүүлэгчид 527, зөвлөгөө авсан 231, шинжилгээ өгсөн-396

БЗДХ-ын кабинетид: Нийт үзлэг-11587 Үүнд: Урьдчилан сэргийлэх-10380 , Идэвхитэй хяналт-441, Өвчний учир- 766 , Шинжилгээнд: ХДХВ-7712, Тэмбүү-7710, Мазок-2088

Өвчлөл: Тэмбүү -38 Заг хүйтэн -93, Трихомониаз -185 илрүүлж тэдний хавьталыг хяналтанд авч эмчилгээнд хамрууллаа.

Манай аймаг 10000 хүн ам тутамд ногдох сүрьеэгийн тархалт, сүрьеэгээс шалтгаалсан нас баралт тогтвортой буурахгүй байна. Сүрьеэгийн диспансерийн хяналтанд 80 үйлчлүүлэгч эмчлэгдэж байна. /үүний дотор уушигны сүрьеэ 29, уушигны бус сүрьеэ 51/ оношийн баталгаажилт 88.8% эдгэрэлтийн түвшин 93.5 %тай. ХДХВ/ДОХ ын үзлэг шинжилгээнд 104 хүн хамрагдсан. Диспансерийн үзлэг 4856, амбулаторийн үзлэг 727 Урьдчилан сэргийлэх үзлэг 4129. Эмнэлэгт хэвтүүлэх болон амбулаториор эмчлэх шалгуур үзүүлэлт боловсрогдож сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношлогооны баталгаажилт, эмчилгээний үр дүн дээшилсэн.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт		Өнөөгийн байдал ²⁰				
		2006	2007	2008	2009	2010
<ul style="list-style-type: none"> Сүрьеэ өвчлөлийн түвшин 10 (10.000 хүн амд) 	улс	18,5	16,6	15,8	15,5	
	хэнтий				17,26	25,08
<ul style="list-style-type: none"> Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт баралт (10.000 хүн амд) 	улс	100000-д	2,9	2,4	2,7	2,8
	хэнтий	бодит тоогоор	5	2	3	3
<ul style="list-style-type: none"> Сүрьеэгийн оношийн баталгаажилт (10.000 хүн амд) 	улс					
	хэнтий	83,2	89,8	88,2	78,1	88,9

• Сүрьеэгийн эдгэрэлтийн түвшин	улс	2.9	2.4	2.7	2.8	
	хэнтий	98,4	90,3	96,8	96,1	93,5

Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх аймгийн стратеги төлөвлөгөөг /2009-2019 он/ боловсруулан хэрэгжүүлж байна. “Лабораторийн чадавхийг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд ХӨСҮТ-тэй хамтран багийн эмч, нийгмийн ажилтан, сумын засаг дарга, эмч нарт 2 удаагийн сургалт хийж 52 хүнийг хамруулсан ба Биндэр -14, Батноров-50, Батширээт-16, Баянмөнх 20, Баян-овоо 10, Бор-өндөр 100 хүний сорьц тээвэрлэж эерэг 5 гарсан байна. Аймгийн хэмжээд нийт сорьцийн шинжилгээнд 641 үүнээс оношлогоо-329 сөрөг-283, эерэг-46 ХӨСҮТ ийн СТСалбанаас сорьц тээвэрлэлт ба сүрьеэтэй тэмцэх сэргийлэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцан үнэлгээ хийж зөвлөмж өгсөн.

Сүрьеэгийн диспансерийн хяналтанд 80 үйлчлүүлэгч эмчлэгдэж байна. /үүний дотор уушигны сүрьеэ 29, уушигны бус сүрьеэ 51/ оношийн баталгаажилт 88.9% эдгэрэлтийн түвшин 93.5 %тай.ХДХВ/ДОХ ын үзлэг шинжилгээнд 104 хүн хамрагдсан.Диспансерийн үзлэг 4856, амбулаторийн үзлэг 727 Урьдчилан сэргийлэх үзлэг 4129. Эмнэлэгт хэвтүүлэх болон амбулаториор эмчлэх шалгуур үзүүлэлт боловсрогдож сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношлогооны баталгаажилт, эмчилгээний үр дүн дээшилсэн

Шүд эмчлэх, эрхтэн тогтолцооны өвчний оношлогоо, эмчилгээний арга, технологийг сумын түвшинд нэвтрүүлэх

Хэрэгжилтийн явц

Эрүүл мэнд нийгмийн хамгаалалын сайдын 191 тушаалаар батлагдсан 2000-2010 онд хэрэгжүүлэх “Сохролтой тэмцэх” үндэсний хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын 2006 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан “Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Хүүхдийн шүд цоорох өвчин, хараа, сонсголын эмгэгээс сэргийлэх” дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөл, Аймгийн ИТХТэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж 02-р тогтоолоор батлуулан ажиллаж байна.

Хэрлэн сумын 5 цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын 1-р ангийн сурагчдыг зорилтот бүлэг болгон амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж шүд цооролтын эрчмийг тогтоосон.5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалтын хувь - 82%.2010 онд ХЯБХөтөлбөрийн шугамаар 29,8 сая төгрөгийн өртөгтэйгөөр Нэгдсэн эмнэлэг-1, Тэмүүжин цогцолбор сургууль 1 нийт 2 ш шүдний “Бор” машин олгогдож, сургуулиудыг мэргэжлийн шүдний эмчээр хангах бодлого барьж, Тэмүүжин ЦС-ийг шүдний эмчтэй болгож, Нэгдсэн эмнэлгийн шүдний 2 кабинет, үүдэн эмнэлгүүдэд сургууль, цэцэрлэгийг хувиарлан эрүүлжүүлэх арга хэмжээ авч эхлээд байна.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал			
5-6 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалт 75 хувь	Хэрлэн сумын хэмжээнд 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалтын хувь – 75,8%. Цаашид сумдад энэ үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.			
Шалгуур үзүүлэлтүүд /7/		2008 он	2009 он	2010 он
5-6 настай хүүхдийн дунд шүд цоорлын тархалтын хувь		77%	76%	75.8%

12 настай хүүхдийн дунд шүд цоорлынтархалтын хувь	65%	64%	63.1%
Нийт хүн амын дунд шүд цоорлын тархалтын хувь	75,5%	75%	74.8%
5-6 настай хүүхдийн дунд шүд цоорлын эрчим	4,2%	4,1%	4.0%
12 настай хүүхдийн дунд шүд цоорлын эрчим	2,3%	2,3%	2.2%
Нийт хүн амын дунд шүд цоорлын эрчим	3,2%	3,1%	3.0%
18 настай хүүхдийн дунд бүрэн шүдтэй хүүхдийн эзлэх хувь	67,5%	68%	68.4%

Дүгнэлт: Улсын хүрэх түвшинтэй харьцуулахад нийт хүн амын дунд шүд цоорлын тархалтын хувь өндөр байгаа ч өмнөх онтой харьцуулахад буурч байгаа нь харагдаж байна. Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр нийгэм хамт олонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бий болгон түүний чанар, хүртээмж нь дээшлүүлэн ажиллаж байгаа боловч аймгийн хэмжээнд шүдний бор машиныг 7, шүдний их эмчийг 8 болгон нэмэгдүүлсэн ч цаашид боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хангалтын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаад дүгнэлт хийж ажиллаж байна.

4.2.1.1. Хувийн секторын хөгжил ба жижиг дунд үйлдвэрлэл

Бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

Хувийн хэвшил, Засгийн газрын байгууллагуудын түншлэлийг дэмжин хөгжүүлж, бэхжүүлнэ.

Хэрэгжилтийн явц

“Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”²¹-ийг орон нутагтаа хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Хэнтий аймгийн Засаг даргын 2010 оны 31 дүгээр захирамжийн дагуу “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан 13 хүний бүрэлдэхүүнтэй томилсон.

Аймгийн Барилгачдын холбооноос аймгийн ИТХ, ЗДТГ-т МУ-ын Засгийн газраас зарласан “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн ажлыг амжилттай хэрэгжүүлсэний баталгаа болгож **ТАЛАРХАЛ** хадгалуулсан байна.

Аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад мөрдөгдөж буй **дүрэм журмыг нягтлан шалгах, журамлах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг** Засаг даргын захирамжаар байгуулж, уг ажлын хэсэг аймгийн МХГ-ын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс зэрэг байгууллагуудад ажиллаж хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг хянаж үзэхэд МХГ-аас иргэдэд эрүүл мэндийн дэвтрийг үндэслэлгүй олгож, төлбөр хураамж авч байсан, ЕБС-ийн сурагчдаас үндэслэлгүй төлбөр хураамж авдаг, Хэрлэн сумын ЗДТГ-аас иргэдэд тодорхойлолт олгохдоо хураамж авдаг, Улсын бүртгэлийн хэлтэс үйлчилгээний төлбөр хураамжийг үндэслэлгүй нэмэгдүүлсэн, Биндэр сумын ИТХ-аас баталсан иргэдэд эрүүл мэндийн

²¹ Засгийн газрын 2009 оны 299-р тогтоол

үйлчилгээг төлбөртэй үзүүлэх журам гаргасан зэрэг олон зөрчлийг илрүүлж дээрх шийдвэрүүдийг хүчингүй болгох талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг өгч биелэлтэнд хяналт тавьж ажилласан.

Орон нутгийн бизнес эрхлэгчдээ дэмжих зорилгоор 2010 онд хийгдсэн зам, барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэгчийн болон тоног төхөөрөмж бараа материал нийлүүлэгчийн сонгон шалгаруултад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулинд заасны дагуу **орон нутгийн давуу эрх тооцож ажилласанаар** энэ жил нийт 70 худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас орон нутгийн 38 аж ахуйн нэгж байгууллага шалгарч үйл ажиллагаа нь дэмжигдсэн.

“Бид бизнес эрхлэгчдэд ямар дэмжлэг үзүүлж чадах вэ” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг 2010 оны 4 дүгээр сард төрийн болон төрийн бус байгууллагууд, төсөл хөтөлбөрийн 19 байгууллагын 30 гаруй иргэдийг хамруулан зохион байгууллаа. Уулзалт зөвлөгөөнөөр бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг бэрхшээлийг тодорхойлж эдгээрийг яаж багасгах тал дээр хамтран ажиллахаар шийдвэрлэж ажлын хэсгийг байгуулан хамтран хийх 5 үндсэн ажлаа тодорхойлон хэрэгжүүлсэн. Хэнтий аймгийн ЗДТГ, аймгийн ҮЭХороо, аймгийн Ажил олгогч эздийн холбоо хамтарсан 2010-2011 оны Нийгмийн зөвшилтийн 3 талт хэлэлцээрийг 2010 оны 3 дугаар сард байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Төр - Хувийн хэвшлийн түншлэл - 2010” зөвлөгөөнийг 2010 оны 4 сарын 19-нд Өндөрхаан хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнд ММСС ТМБС, БУАХШ дэд төсөл, аймгийн ЗДТГ, Хэрлэн сумын ИТХ, ЗДТГ, аймгийн ҮЭ-ийн зөвлөл, ХАҮТ, АОЭХ, хувийн хэвшлээс 60 гаруй төлөөлөгч, нийт 100 орчим хүн уригдан оролцсон. Зөвлөгөөнд оролцогчид “Төр – Хувийн хэвшлийн Түншлэл”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн төр, хувийн хэвшлийн байгууллагууд болон МСҮТ-д хандаж зөвлөмж гаргасан.

Улмаар **“Хан-Хэнтий түншлэл-2010”** аймгийн Хөдөлмөрийн бага чуулганыг нийгмийн түншлэлийн гурван талын оролцоотойгоор 2010 оны 5 сард төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, 60 гаруй ажил олгогчдийг хамруулан Өндөрхаан хотод зохион байгуулж хөдөлмөрийн харилцаанд талуудын өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замын талаар хэлэлцэж зөвлөмж гаргасан.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно.

Хэрэгжилтийн явц

“Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-ийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/-аас чөлөөлөх тухай”²² хууль, “Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөгдөх ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт”-ыг баталсан²³. “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”²⁴-ийг хэрэгжүүлж байна.

“Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл”²⁵ –ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны 3 сарын 15-ний өдрийн 56 дугаар захирамжаар төсөл сонгон шалгаруулах дэд комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж 2010 онд аймгийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сан”-д бүрдсэн 650 сая төгрөгийг 2010 онд зарцуулах 13 чиглэлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2010 оны 25 дугаар тогтоолоор батлуулсан. Зээл олгох чиглэлд:

- Ундаа, жүүс, цэвэр усны үйлдвэрлэл

²² Улсын Их Хурал 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан.

²³ Засгийн газрын 2009 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 316 дугаар тогтоол

²⁴ Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 173 дугаар тогтоол

²⁵ Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 178 дугаар тогтоол

- Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Цемент, тоосго, бетон хийц, барилгын материалын үйлдвэрлэл
- Ариун цэврийн цаасны үйлдвэрлэл
- Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэл
- Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Шувуу, гахай, зөгийн аж ахуй хөгжүүлэх
- Жимс, жимсгэнэ тариалах, боловсруулах үйлдвэр, хүлэмжийн аж ахуй
- Арьс шир боловсруулах үйлдвэр /байгаль орчинд халгүй/
- Малын тэжээлийн цех болон мал бордох аж ахуй
- Ахуйн үйлчилгээний төв байгуулах
- Ашиг шим өндөртэй үржлийн сүргийн аж ахуй

2010 онд нийт 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 45 төслөөс үндсэн шалгуур үзүүлэлтэнд нийцэж дэмжигдсэн 981,3 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 30 төслийг ХААН банкны судалгаанд ишлжүүлснээс **20 төсөлд 650 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олголоо.** Уг хөнгөлөлттэй зээлийн хүрээнд шинээр 12 үйлдвэрлэл байгуулагдаж, 8 үйлдвэрлэлийн үйл ажиллагаа өргөтгөгдөн, сэргээгдэж шинээр 150 ажлын байр нэмэгдэж, 26 ажлын байр хадгалагдаж үлдэх боломж нөхцөл бүрдээд байна.

2010 онд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс шинээр цэвэр усны үйлдвэр болон барилгын материалын үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлэн орон нутгийн хэрэглэгчдийн хэрэгцээнд бүтээгдэхүүнээ нийлүүлж байна

Нийт зээлдэгчдийн хувьд:

- Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 4 төсөлд 115,4 сая төгрөг
- Хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 2 төсөлд 70 сая төгрөг
- Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр 3 төсөлд 135 сая төгрөг
- Ахуйн үйлчилгээний төв байгуулах 1 төсөлд 18,4 сая төгрөг
- Эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйн чиглэлээр 10 төсөлд 311,2 сая төгрөгийг тус тус олгожээ.

“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сан”-гийн үйл ажиллагаа, зээл олголтийн талаар болон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор орон нутгийн “Дөлгөөн Хэрлэн” FM 106.2 радиотой хамтран Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин **“Амжилтын зам” нэртэй 16 цуврал** нэвтрүүлгийг бэлтгэн явуулсан байна.

Бизнес эрхлэгчдэд зориулсан **“Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл”** сургалтыг ХХҮХэлтсээс 4 удаа 98 хүнийг, Монгол улсад үйлдвэрлэл хөгжүүлбэ төслийн хүрээнд Хэрлэн бизнес төвөөс 2 удаа 30 хүнийг, ХААҮШУОНТ-өөс “Хэвлэлийн эх бэлтгэх” сургалтыг онлайнаар 10 хүнийг хамруулан зохион байгуулав. Өмнөдийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд аймгийн фермерийн аж ахуй, бизнес эрхлэгчдэд “Малын тэжээл үйлдвэрлэл, зохиомол хээлтүүлэг” сургалтыг 28 хүнд явуулсан.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
-----------------------	-----------------

ЖДҮ-ийн үйл ажиллагаа жигдэрч хорших, дагнах, экспортын чиг баримжаатай үйлдвэрүүд нэмэгдэн, ЖДҮ эрхлэгчдийн тоо 2 дахин өснө	Үзүүлэлт	2007	2008	2009	2010
	ЖДҮ эрхлэгчдийн тооны өсөлтийн хувь /өмнөх оныхтой харьцуулснаар/ ²⁶	6,7	65,9	32,3	15,6
Лизингийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тооны өсөлт - Үйлдвэрлэлийн өсөлт 2-3 дахин өснө	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх ажлыг 2010 оны сүүлийн хагас жилээс зохион байгуулж эхэлсэн тул уг үйлчилгээнд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр, тоног төхөөрөмжийн тооны өсөлт гаргах хугацаа болоогүй.				
	Үзүүлэлт	2007	2008	2009	2010
	ЖДҮ-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний жилийн өсөлтийн хувь /өмнөх оныхтой харьцуулснаар/	-0,2	15,8	8,0	69,6
Мэргэжлийн холбоод болон ТББ-тай хамтран шийдвэрлэсэн асуудал - Төрийн байгууллага болон мэргэжлийн холбоод, ТББ-тай хамтран ажиллана	<i>Хэнтий аймгийн ЗДТГ, аймгийн ҮЭХороо, аймгийн Ажил олгогч эздийн холбоо хамтарсан 2010-2011 оны Нийгмийн зөвшилийн 3 талт хэлэлцээрийг 2010 оны 3 дугаар сард байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.</i>				
Шинээр байгуулагдсан бизнес инкубаторын тоо - ЖДҮ эрхлэгчид чадавхиана. Туршлага судлах боломж бүрдэнэ. Эрсдэлээс хамгаалагдана.	Бизнес хөгжлийг дэмжих сургалтын төв байхгүй. Бизнес инкубаторийг байгуулах саналыг байнга тавьж байгаа хэдий ч хөрөнгө санхүүгийн дутагдлаас шалтгаалан хэрэгжихгүй байна.				

“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сан”-гийн хөнгөлөлттэй зээлийг 2009 онд ХАС банкаар дамжуулан олгосон нь иргэдэд хөрөнгө мөнгө болон цаг хугацааны хувьд хүндрэл бэрхшээлтэй байгааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар болон “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-д хүсэлт тавин уламжилж **2010 оны хөнгөлөлттэй зээлийг ХААН банкаар дамжуулан олгосон** нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн цаг хугацаа, мөнгө хөрөнгийг хэмнэсэн үр дүнтэй ажил болсон байна.

Мөн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад тухайн аж ахуйн нэгжээс бүрдүүлдэг байсан 10 нэр төрлийн **бичиг баримтын тоог цөөлж шат дамжлагыг багасгасан.**

ЖДҮ-ийг дэмжих, тэдэнд учирч буй хүндрэлийг арилгах чиглэлээр тодорхой арга хэмжээ авагддаг ч ижил төстэй дүрэм журам, хяналт шалгалтын давхардал ЖДҮэрхлэгчдэд хүндрэл учруулсаар байна. ЖДҮ-ийн хөгжилд авилга, зээлийн өндөр хүү, бизнесийн шударга бус өрсөлдөөн²⁷ нь хамгийн их саадтай байна.

4.2.1.2. Зам тээврийн хөгжлийн бодлого

²⁶ ЖДҮ-ийн газар “ЖДҮ-ийг дэмжих” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан <http://www.mofa.gov.mn/mn/images/stories/tailan/jijigdund2009.pdf>

²⁷ ГТХАН-ийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” төслийн ажилтнуудын судалсан судалгааны дүн

Авто замын сүлжээг өргөжүүлнэ.

Өндөрхаан хотын авто замын сүлжээ, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулна.

Авто замын салбарт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн чанарыг дээшлүүлж, ашиглалт үйлчилгээг сайжруулна.

Хэрэгжилтийн явц

Монгол Улсын нийт авто замын сүлжээ байгуулах, хатуу хучилттай авто замын хэмжээг нэмэгдүүлэх, зорчигч тээврийн үйлчилгээний чанар, тохилог байдлыг хангахад чиглэгдсэн стратегийн 3 зорилт, хэрэгжүүлэх 8 арга хэмжээг МХЗ-д суурилсан ҮХЦБ-д тусгажээ.

Өндөрхаан авто замын сүлжээнд сүүлийн 3 жилд орсон өөрчлөлт

Үзүүлэлт		2008	2009	2010	Нийт дүн
Ашиглалтад оруулсан зам км /улс, орон нутаг хамтдаа/		77,65	1,4	5,6	84,65
Хөрөнгө оруулалт	Дотоодын хөрөнгө оруулалт, тэрбум төг		0,329	1,151	1,48
	Гадаадын зээл тусламж, сая ам. дол.				

Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Зүүн чиглэлийн гол автозам барих, тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд Хэнтий аймгийн зам засвар арчлалтын “Харгуй” ХХК-д 2 тэрбум гаруй төгрөгийн 19 төрлийн автозамын техник хэрэгслийг, асфальтбетон завод, чулуу бутлуурын заводын хамт буцалтгүй тусламжаар олгосон. Үүний дүнд зам засвар арчлалтын Харгуй ХХК-нь улсын чанартай 250 км хатуу хучилттай, 420 гаруй км сайжруулсан шороон замын засвар арчлалт, ашиглалт, үйлчилгээг чанартай гүйцэтгэн, Өндөрхаан хотод шинээр асфальтбетон автозамыг чанартай гүйцэтгэж байна.

2004-2008 оны хооронд "Мянганы зам" төслийн хүрээнд манай аймгийн нутаг дээр Хэрлэнгийн гүүр-Өндөрхааны чиглэлийн 192 км хатуу хучилттай автозам, Цэнхэрийн голын 60,7 у/м, Мөрөнгийн голын 52.4 у/м төмөр бетон гүүр, Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 50 км хатуу хучилттай автозамыг барьсан бол Өндөрхаан-Сүмбэрийн 50 км замыг Насны зам ХХК үргэлжлүүлэн барьж байгаа бөгөөд 2009-2010 онд уг замын барилгын ажилд улсын төсвийн хөрөнгөөр 8 тэрбум төгрөг тусгагдан газар шорооны ажлууд хийгдээд байна. 2010 онд улсын төсвийн 700,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цэнхэрмандал сумын төвийг мянганы замтай холбосон 3,3км автозамыг Хансуун зам ХХК барьж ашиглатанд оруулсан.

Өндөрхаан хотын доторхи автозамыг сайжруулах аяны хүрээнд 2009 онд 329.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1,4 км, 2010 онд 1.3 км хатуу хучилттай асфальтбетон автозамыг 351.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зам засвар арчлалтын "Харгуй" ХХК гүйцэтгэлээ. Мөн 100,0 сая төгрөгийн хөрөнгөөр 1км цементбетон авто замыг аймгийн ШХБХБГазрын инженерүүд, Онцгой байдлын газар, дүйцүүлэх цэргийн албан хаагчдын хүчээр барьж ашиглатанд орууллаа. 2009 онд Дархан сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Тунсинь ХХК төмрийн хүдрийн уурхайгаас Бор-өндөр хот руу 16 км хайрган хучилттай автозамыг өөрийн хөрөнгөөр тавьсан.

2010 оны 9 сард ажлын хэсэг Өндөрхаан-Дадал чиглэлийн 270км шинээр тавигдах хатуу хучилттай авто замын маршрут болон хөрсний шинжилгээг ОХУ-ын Союзстрой ХХК-ний мэргэжилтнүүдтэй хамтран хийсэн.

2010 онд аймгийн Засаг даргын захирамжаар 500.0 мянган төгрөгийг шийдвэрлэж Өндөрхаан хотод шинээр баригдсан 2.3 км автозам болон бусад автозамууд дээр 12 ширхэг тэмдэг, тэмдэглэгээг тавилаа. Орон нутгийн төсвийн 5,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Сүлжээт зам” ХХК Өндөрхаан хотын төв гудамжинд гэрлэн дохио суурилуулсан.

Аймгийн Тээвэр, авто замын газар нь хот хооронд болон орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээ, улсын болон орон нутгийн чанартай зам, гүүрийн хэвийн үйл ажиллагааг орон нутагт хангах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Улаанбаатар хотын чиглэлд Өндөрхаан, Бор-Өндөр хот, Дадал сумдаас тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгуулагууд тогтмол үйлчилж байна. Орон нутагт Шуудан үйлчилгээний газар бүх сумдад 7 хоногт 1-3 удаа зорчигч, тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

2010 онд улсын төсвийн 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотын нийтийн тээвэрт 3, Хэрлэн сумын Тахилгат тосгоны ЗАА, Баян-адрага сумын ЕБСургуульд тус тус 1 ширхэг истана маркийн бага оврын автобусыг авч өгсөн. Одоо Өндөрхаан хотын нийтийн тээвэр тогтсон график маршрутын дагуу хэвийн явагдаж байна.

Үр дүн

Аймгийн төв Өндөрхаан хот, Мөрөн, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумд хатуу хучилттай автозамаар, Бор-Өндөр хот төмөр замаар холбогдсон. Улсын чанартай 672 км автозам үүнээс 250 км зам хатуу хучилттай, 4ш төмөр бетон гүүртэй, Орон нутгийн чанартай 1993 км зам, 3ш төмөр бетон, 12 ш модон гүүртэй. Агаарын болон усан замын тээвэргүй.

Сүүлийн гурван жилийн байдлаар улсын чанартай авто зам, хотын автозамын сүлжээг өргөсөшөхөд онцлон анхаарч ажиллаж байна. Тухайлбал **улсын чанартай хатуу хучилттай зам** 2007 онд 173км, 2008 онд 250,км болж нэмэгдсэн. Хотын доторхи автозам 2008 онд 650м, 2009 онд 1,4км, 2010 онд 2,3км зам барьж ашиглалтанд оруулсан.

Барилгын салбарын хөгжлийн бодлого

- **Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. “40000 орон сууц” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.**

Хэрэгжилтийн явц

Уг хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймагт 200 айлын орон сууц барих дэд хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжүүллээ. 2005 онд баригдан ашиглалтанд орсон орон сууцны санхүүжилтээс тодорхой хувиар орон сууцны санг бүрдүүлж эхэлсэн. Энэ сангийн журмаар МШБ-тай хамтран орон сууцны хөнгөлөлттэй зээлийг олгож үүнд төрийн албан хаагч 32 өрх хамрагдаад байна. Орон сууцны инженерийн шугам сүлжээ бүхий эдэлбэр газартай болон орон сууцны 4.6 га газрыг төлөвлөн гэр хорооллын нөхцөл сайжруулах төслийн хөрөнгөөр 5.3 км газрын бохир цэвэр усны шугам хоолой угсрах ажлыг 2006 онд хийсэн.

Ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууц баригдах газар нөхцлийн тухай мэдээллийг иргэд, аж ахуйн нэгжид өгч, ингэснээр 2006 онд 12 айлын орон сууц баригдан ашиглалтанд орж, мөн 12 айлын сууцны газрын зөвшөөрөл техникийн нөхцлийг олгов. 2007 онд аймгийн төвд 40 айлын 1 орон сууц, 6 суманд 4 айлын тус бүр 1 орон сууц 3 суманд 4 айлын 2 сууцнууд барихаар техникийн нөхцлүүдийг олгож, ОССКорпорациас тендер зарласан боловч хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан сумдад баригдах орон сууцнууд эхлээгүй. Өндөрхаан хотод 40 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж дуусан барилга угсралтын ажил 3-р давхрын өрлөгийн ажил хийгдсэн.

Орон сууц санхүүжилтийн корпоациас 2008 онд аймгийн төвд 20 айлын орон сууц бариулж эхлээд газар шорооны ажил нь дуусан санхүүжилтгүйн улмаас зогсоод байна. Мөн орон нутгийн нөөц бололцоог дайчлан аймгийн төвд хуучин БХТН-ийн олон жил ашиглалтгүй байсан барилга болон аймгийн нэдсэн эмнэлэгийн өргөтгөл баригдаж байгаатай холбогдон суларч байгаа хуучин эмнэлэгийн барилгыг ашиглан зориулалтыг өөрчлөн төрийн албан хаагчийн болон эмнэлгийн ажилчдын орон сууц болгон засч дуусган нийт 36 өрхийг орон сууцаар хангасан.

2009 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотод 21 айлын, Бор-Өндөр хотод Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар 21 айлын орон сууц, 2010 онд Өндөрхаан хотод компанийн хөрөнгө оруулалтаар 48 айлын орон сууц, эмнэлгийн хуучин барилгын зориулалт өөрчлөн 21 айлын сууц болгон засч тус тус ашиглалтад оруулаад байна.

40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн хэмжээнд баригдах 200 айлын орон сууц барих дэд төсөл болосруулж хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөж газрын байршил тогтоон техникийн нөхцлийг олгон зураг төсвийг хийгээд байна.

Нийтийн эзэмшлийн орон сууц барих хүсэлтэй аж ахуйн нэгжид төсөл сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаагаар олгох газрын төлөвлөгөөг гарган баталж газар олгон иргэд хувийн орон сууц барьсаар байна.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал				
Орон сууц хөтөлбөрийн сангийн хөрөнгийн хэмжээ	Санд 2005-2010 онд 350,0 сая төгрөг хуримтлагдаж, төрийн албан хаагчдад орон сууцны зориулалтаар зээл хэлбэрээр зарцуулсан.				
200 айлын орон сууц барих	2006	2007	2008	2009	2010*
	12 айл	36 айл	Хуучин барилга зориулалт өөрчлөн засч 36 айл	21 айлын 3 орон сууц, 12 айлын 1 орон сууц	48 айл
Инженерийн шугам сүлжээ бүхий хувийн сууцны 2 хороолол бий болгоно	2008 онд инженерийн шугам сүлжээ бүхий хувийн сууцны 2 хэсэг бичил хороолол байгуулах газар зохион байгуулалтыг хийж цэвэр бохир усны шугмыг угсарсан. Уг газрыг хувийн орон сууц барих иргэдэд эзэмшилтээр олголоо				

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2006-2010 онуудын үндсэн чиглэл, орон сууцны салбарын бодлогын баримт бичгүүд, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд бага орлоготой иргэд, нийгмийн эмзэг хэсэгт зориулсан орон сууцны татаас, хөнгөлөлтийг бий болгох асуудал тусгагдаагүй байна.

Орон сууц хөтөлбөрийн сангийн үйл ажиллагааг жигдрүүлэн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай.

4.2.2.4. Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэх

Хэргжилтийн явц

Хэнтий аймагт үржүүлж буй цэвэр, эрлийз, нутгийн шилдэг омгийн малын цөм сүрэг, үржилд ашиглаж байгаа нийт хээлтүүлэгчийн ашиг шимийн түвшинг тодорхойлж, үзлэг ангилалт хийн цөм сүргийг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг жил бүр зохион байгуулж хэвшээд байна. Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж буй бух, хуц, ухныг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 17 сум, 5 тосгонд жил бүр зохион байгуулж, жилд дунджаар 8-10 мянган толгой хээлтүүлэгч, 15-16 мянган толгой хээлтэгч малыг үзлэг ангилалтанд хамруулж байна. 2010 онд үзлэг ангилалтанд **7948** толгой эм хонь, **2602** толгой эм ямаа, **5344** толгой үнээ, **5292** толгой хуц, **2906** толгой ухна, **256** толгой бух, нийт 13240 толгой хонь, 5508 толгой ямаа, 5600 толгой үхэр, 24348 толгой мал хамрагдлаа.

Малчин өрхийн сүргийн чанарыг сайжруулах, хээлтүүлэгч малын биологийн чадавхийг бүрэн ашиглах, ашиг шимийн түвшинг дээшлүүлэх, сүргийн бүтцийг оновчтой бүрдүүлэх, нутгийн шилдэг омгийн мал болон цэвэр, эрлийз малын тоог нэмэгдүүлэх зорилгоор сум болгонд цөм сүрэг бүхий өрх айлыг бий болгож, үржлийн бүртгэл хөтлөн ажиллалаа. Уг ажлын хүрээнд 17 суманд 24 цөм сүрэг бүхий өрх бий болж, ХХААЖДҮГазар, Сумын Засаг дарга, малчин нарын гурвалсан гэрээ байгуулаад байна.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал				
	малын тоо	2007	2008	2009	2010
Цөм сүргийн малын тоо 2008 онтой харьцуулахад 10 хувиар өссөн байна (ШҮ- Цөм сүргийн малын тооны өсөлт)	Нийт малын тоо / мян. тол /		2136.9	2251.0	2180.7
	Цэвэр үүлдрийн мал / мян. тол /		397	475	544
	Эрлийз мал / мян. тол /		955	1150	1227
	Нутгийн шилмэл омгийн мал / мян. тол /		150870	151560	168962
	Нийт цөм сүргийн малын тоо / мян. тол /		2670	3255	5322
	Цөм сүргийн нийт малд эзлэх хувь	0.7	1	1.6	1.5
	Аймгийн хэмжээнд нийт малын тоо 70.4 мянган толгойгоор буурсан нь өмнөх жилүүдийн зудын байдалтай холбоотой юм. Цөм сүргийн тоо өмнөх оныхоос 2000 гаруй толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь сум бүрт цөм сүрэг бүхий өрх айл бий болсонтой холбоотой юм. Цаашид цөм сүрэг бүхий өрхүүдэд үржүүлэгдэж буй хээлтэгчийн тоог нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.				
Мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэн биотехнологийн үйлдвэрлэлийн ололтыг нэвтрүүлсэн байна	Аймгийн хэмжээнд зохиомол хээлтүүлгийн 6 цэг ажиллаж байгаа бөгөөд энэ онд ХЯБХ –ийн хөрөнгөөр Дадал суманд явуулын 1 цэг шинээр байгуулаад байна. 187 үнээ, 1500 эм хонинд зохиомол хээлтүүлэг хийлээ. Мах-ноосны чиглэлийн ТНЦ үүлдрийн хонины удмын санг хамгаалах зорилгоор уг хониос үр авч удмын сангийн үндэсний төвд хадгалуулах ажлыг зохион байгууллаа. Цөм сүрэг бүхий өрхүүдээс 500 гаруй толгой өсвөр хээлтүүлэгч бойжуулаад байна.				

Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ
Хэрэгжилтийн явц

Мал аж ахуйн өвөлжилт, хадлан тэжээл бэлтгэлийн ажилд аймаг, сум, малчин өрх бүр идэвх санаачлагатай оролцох, өвс тэжээл бэлтгэх, нөөцлөхөд онцгойлон анхаарч ажилласны дүнд аймгийн хэмжээнд энэ онд 127.8 мянган тонн байгалийн хадлан, 1889.3 тонн ногоон тэжээл, 458.5 тонн үйлдвэрийн тэжээл, 131.9 тонн гар тэжээл тус тус бэлтгэсэн ба төлөвлөгөөт өвсийг 102.2%, ногоон тэжээлийг 9 дахин, үйлдвэрийн тэжээлийг 101.8%, гар тэжээлийг 131.9% давуулан биелүүллээ.

Мөн аймгийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалах санд 375 тонн өвс, 350 тонн тэжээл, сумын аюулгүйн нөөцөд 1739 тонн өвс тус тус бэлтгэсэн нь өмнөх жилүүдтэй харьцуулахад 36-40 мянган тонноор илүү өвс тэжээл бэлтгэсэн байна. 2010 онд сум бүрт 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, өвсний нөөц бүрдүүлээд байна.

ХХААХҮЯамтай хамтран 6.0 тонн хөх тариа, 1.0 тонн овъёос, 0.3 тонн царгасыг малын тэжээл тариалах сонирхол бүхий иргэд, аж ахуй нэгжид гэрээгээр олгосон ба Хэрлэнбаян-Улаан тосгонд 20 га газар, Норовлин суманд 10 –га газар, Хэрлэн сумын иргэн Гансүх -1,5 га газар эрдэнэ шиш, манжин, “ Хэнтий сүү “ хоршоо 10 –га газар хөх тариа тариалж малын дарш, тэжээлийг бэлтгэлээ. Мөн Өмнөдэлгэр сумын иргэн Баатар 70 га талбайд Цагаан арвай , Хурх гол ХХК 100 га-д овъёос, 370 га-д ногоон тэжээл тус тус тариалсан. 2010 онд аймгийн хэмжээнд малын тэжээл 458.6 га, овъёос 482 га-д нийт 5 аж ахуйн нэгж, 1 хоршоо, 4 иргэн тариалж, 1889.3 тонн малын тэжээл хурааж авсан

Шимт чанар сайтай тэжээлийн ургамлыг хадаж өвс, өвсөн дарш, гар тэжээл бэлтгэх гарын авлагыг 17 сум 5 тосгонд тараасан бөгөөд энэ чиглэлээр ХЯБХөтөлбөр, аймгийн ХААНТөвтэй хамтран сургалт зохион байгуулж ажиллалаа.

Өмнөдэлгэр сумын "Өндөрхаан" ХК нь тэжээлийн цех байгуулах зорилгоор ЖДҮ-ийг дэмжих дэд сангаас 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйл ажиллагаа эхлүүлэхээр болсон ба ХЯБХөтөлбөрийн дэмжлэгээр аймгийн төв Хэрлэн суманд жижиг оврын тэжээлийн цех байгуулагдаад ажиллаж байна.

Үр дүн

Үзүүлэлт	2007	2008	2009	2010
Хураасан тэжээлийн ургамал /мян.тн/		0,1	0,179	3,704

Үзүүлэлт	2007	2008	2009	2010
Хадлан /мян.тн/	83,7	85,0	91,2	127,8
Гар тэжээл /тэжээлийн нэгжээр/	0,100	0,89	0,102	0,131

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
"Малын тэжээл" хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрэх үр дүнгээр	ХХААХҮЯамтай хамтран 6.0 тонн хөх тариа, 1.0 тонн овъёос, 0.3 тонн царгасыг малын тэжээл тариалах сонирхол бүхий иргэд, аж ахуй нэгжид гэрээгээр олгосон ба Хэрлэнбаян-Улаан тосгонд 20 га газар, Норовлин суманд 10 –га газар, Хэрлэн сумын иргэн Гансүх -1,5 га газар эрдэнэ шиш, манжин, “ Хэнтий сүү “ хоршоо 10 –га газар хөх тариа тариалж малын дарш, тэжээлийг бэлтгэлээ. 2010 онд аймгийн хэмжээнд малын тэжээл 458.6 га, овъёос 482 га-д нийт 3 аж ахуйн нэгж, нэг хоршоо, 3 иргэн тариалж, 1815 тонн малын тэжээл хурааж авсан. Мөн Хэрлэн сумын “Өндөрхаан” ХК

		Өмнөдэлгэр суманд тэжээлийн цех байгуулах зорилгоор ЖДҮ-ийг дэмжих дэд сангаас 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, ХЯБХөтөлбөрийн дэмжлэгээр аймгийн төвд жижиг оврын тэжээлийн цех байгуулагдан ажиллаж байна.
700 тн тэжээл үйлдвэрлэж, 30 тэжээлийн үйлдвэртэй болно (ШҮ- Тэжээлийн үйлдвэрийн тоо, үйлдвэрлэсэн тэжээлийн хэмжээ)		Аймгийн хэмжээнд энэ онд 125 мянган тонн байгалийн хадлан, 210 тонн ногоон тэжээл, 450 тонн үйлдвэрийн тэжээл, 100 тонн гар тэжээл бэлтгэхээр төлөвлөж, уг ажилд 1278 техник хэрэгсэл, 3007 хүн хүч гарч, 127.8 мянган тонн байгалийн хадлан, 1889.3 тонн ногоон тэжээл, 458.5 тонн үйлдвэрийн тэжээл, 131.9 тонн гар тэжээл тус тус бэлтгэсэн ба төлөвлөгөөт өвсийг 102.2%, ногоон тэжээлийг 9 дахин, үйлдвэрийн тэжээлийг 101.8%, гар тэжээлийг 131.9% давуулан биелүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын нөөцөд 225 тонн өвс, 350 тонн тэжээл, сумын аюулгүйн нөөцөд 1739 тонн өвс тус тус бэлтгэлээ. Өмнөх онтой харьцуулахад хадлан 36599тн, гар тэжээл 27,9тн-оор нэмж бэлтгэсэн байна. Аймгийн Засаг даргын нөөцөд 1964 тонн өвс, 350 тонн тэжээлийн нөөцийг бүрдүүлсэн. Сумын нөөц бүрдүүлэхэд орон нутгийн нөөцөөс сум бүрт 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр сум тус бүр 100 тн өвсийг нөөцлөөд байна.
1200,0 мян.тн байгалийн хадлан бэлтгэж аливаа эрсдлээс хамгаалагдана (ШҮ- Бэлчээр хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр дэмжлэг авсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо)		Аймгийн хэмжээнд энэ онд 125 мянган тонн байгалийн хадлан, 210 тонн ногоон тэжээл, 450 тонн үйлдвэрийн тэжээл, 100 тонн гар тэжээл бэлтгэхээр төлөвлөж, уг ажилд 1278 техник хэрэгсэл, 3007 хүн хүч гарч, 127.8 мянган тонн байгалийн хадлан, 1889.3 тонн ногоон тэжээл, 458.5 тонн үйлдвэрийн тэжээл, 131.9 тонн гар тэжээл тус тус бэлтгэсэн ба төлөвлөгөөт өвсийг 102.2%, ногоон тэжээлийг 9 дахин, үйлдвэрийн тэжээлийг 101.8%, гар тэжээлийг 131.9% давуулан биелүүлсэн.

Малын тэжээлийн үйлдвэрлэл хангалттай түвшинд хэрэгжиж чадахгүй байна. Мөн улсын төсвөөс тэжээл үйлдвэрлэх чиглэлээр олгосон хөрөнгийн зарцуулалт, нийт тэжээл үйлдвэрлэл болон малын тэжээлийн хангамжид үзүүлэх нөлөөллийн тогтмол мониторинг үнэлгээ хийж байх шаардлагатай байна. Ингэснээр малын байгалийн эрсдлээс хамгаалах боломж дээшилнэ.

Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах
Хэрэгжилтийн явц

Сумдад бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах, тарималжуулах талаар малчид, мал бүхий иргэдэд сургалт зохион байгуулж уг ажилд иргэдийг татан оролцуулах, идэвхийг өрнүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2010 онд Тогтвортой амьжиргаа-2 төслийн хөрөнгөөр Жаргалтхаан сумын 2 багт 17 га хадлан, бэлчээрийн талбайг 7.0 сая төгрөгийн санхүүжилтээр хашаажууллаа. Мөн Гамшгийн эрсдлийг бууруулах Мон 08-305 төслийн хүрээнд 3 га бэлчээрийг хашаалан ирэх хавар олон наст ургамал тариалах бэлтгэлийг хангаад байна.

2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 135 сая төгрөгөөр “Буян-Уул” ХХК Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Баян-Адарга, Норовлин, Баян-Овоо, Батноров, Хэрлэн сумдад инженерийн хийцтэй 10 худаг, ХЯБХөтөлбөрийн хөрөнгөөр 11 х удаг тус тус шинээр

гаргалаа. Малчид иргэдийн оролцоотойгоор, 2010 онд 29, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 21 энгийн уурхайн худаг гарган ашиглаж байна.

Энгийн уурхайн худаг гаргах заавар зөвлөмжийг боловсруулан 17 сум, 5 тосгонд хүргүүлсэн бөгөөд малчид иргэдийн оролцоотойгоор 29, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 21 энгийн уурхайн худаг гарган ашиглаж байна. 2010 оны аймгийн нийт нутгаар бэлчээрийн даацыг 16 сумын 79 багт тодорхойлоход нийт нутгийн 18.2% нь 1-3 дахин, 5.2% нь 3-5 дахин, 14.3% нь олон дахин бэлчээрийн даац хэтэрсэн гэсэн үзүүлэлт гарсан байна.

Хадлан, бэлчээрийн талбайг хашиж хамгаалан бордох, цас бороо, үерийн ус хуримтлуулан услах зэргээр сайруулан ашиглах замаар Баян-Адарга сумын Мэхээрчийн буланд 20 өрхийн 5 га бэлчээр, Норовлин сумын Мөст, Могойт, Улзын эх, Өндөр дов зэрэг газарт 8 га бэлчээрийг тус тус хашиж хамгааллаа.

Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийгдэх ажил эхлээгүй байна. 2010 онд ХХААХҮСайдтай аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд 80 уст цэгт хайгуулын ажил хийгдэхээр тусгагдсанаар 7 сараас эхлэн 80 уст цэгт усны хайгуул судалгааны ажлыг "Ус амьдрал" ХХК хийж гүйцэтгэсэн.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
Бэлчээрийн даац багтаамжийг шинэчлэн тогтоосон байна	Бэлчээр ашиглалтын эрхзүйн орчин бүрдээгүй. Бэлчээрийн даац, багтаамжийг тогтоох аргачлал шинэчлэгдэн боловсруулагдаагүй тул монгол орны бэлчээрийн нөөц, даац ямар түвшинд байгаа талаар нэгдсэн судалгааны дүн байхгүй.
Аймаг дундын отрын бүс нутагт нийт бэлчээрийн 5 орчим хувийг хамгаалах, аймаг сум бүрт өвс тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн 150 цех бий болсон байна	Хэрлэнбаян-Улаан тосгоны нутгийг тусгай хэрэгцээний газарт авч чиг үүрэг бүхий Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааг байгуулан 2007 оны 09 дүгээр сараас эхлэн ажиллуулж байна 2010 оны 6 дугаар сараас тал хээрийн цөлжилт ихээр явагдаж, бэлчээрийн талхдалд ороод байгаа Галшар, Баянмөнх, Дархан, Баянхутаг сумдад идлэг шонхор шувууны 1000 хиймэл үүрийг шинээр байгуулсан бөгөөд уг ар а х эмжээ нь хөтөлбөрийн хүрээнд идлэг шонхор шувууг хамгаалах, өсгөж үржүүлэхэд чухал нөлөө үзүүлэхийн зэрэгцээ бэлчээрийн талхдалыг биологийн аргаар бууруулахад онцгой ач холбогдолтой юм. Өмнөдэлгэр сумын “Өндөрхаан”ХК, аймгийн ОБГазарт 1,5-3,0 тн/цаг хорголжин болон багсармал холимог тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий 2 ш тэжээлийн цехийг суурилуулан ажиллуулж байна.
4500 инженерийн хийцтэй худаг, гар худаг 1500 гаргасан байна (ШҮ- Малын усан хангамжийн өсөлтийн хувь, Хур борооны усыг хуримтлуулж байгуулсан хөв цөөрмийн тоо)	2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 135 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “Буян-Уул”ХХК нь Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Баян-Адарга, Норовлин, Баян-Овоо, Батноров, Хэрлэн сумдад инженерийн хийцтэй 10 худаг, ХЯБХөтөлбөрийн хөрөнгөөр 11 худаг тус тус шинээр гаргалаа. Мөн 2010 онд 29, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 21 энгийн уурхайн худаг гарган ашиглаж байна. Мөн “Энгийн уурхайн худаг гаргах тухай” гарын авлага зөвлөмжийг боловсруулан бүх сумдад хүргүүлж ажилласан 2010 онд нийт 2 нуур, 17 булгийн эхийг хашиж, хамгаалж, тохижуулаад байна.

Малчдын ундны усны чанарыг нэмэгдүүлэн худгийн ашиглалтыг сайжруулан орчин үеийн ус цэвэршүүлэх арга ажиллагаанд сургасан байна (ШҮ-Худгийн тоо)	Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийгдэх ажил эхлээгүй байна. 2010 онд ХХААХҮСайдтай аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд 80 уст цэгт хайгуулын ажил хийгдэхээр тусгагдсанаар 7 сараас эхлэн 80 уст цэгт усны хайгуул судалгааны ажлыг "Ус амьдрал" ХХК хийж гүйцэтгэсэн.
15.0 сая шоометр усны нөөц бүхий усан сантай боомтууд хөв, цөөрөм баригдана (ШҮ-Шинээр байгуулагдсан зориулалтын гидротехникийн байгууламжийн тоо, хуримтлуулсан усны хэмжээ /мян.шоометр/)	Улсын төсвийн хөрөнгөөр Цэнхэрмандал сумын Түлүүгийн булан хэмээх газар 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 118,3 мянган м3 үер, цас, борооны ус цуглуулах 650 м далан бүхий хөв цөөрмийн байгууламж баригдан ашиглалтад ороод байна.

Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх

Хэрэгжилтийн явц

ХХААХҮЯам, ХААҮШҮОНТөв, "Жайка" ОУБ-ын Мал аж ахуй, газар тариалан хосолсон аж ахуйг хөгжүүлэх, экстейншиний тогтолцоог бэхжүүлэх төсөл 2010 оны 3-р сарын 1-нээс 2013 оны 3-р сарын 1 хүртэл аймгийн ХААНТөв, Хэрлэн, Өмнөдэлгэр сумдад хэрэгжихээр болж судалгааны ажил хийгдэж байна.

ХААҮШҮОНТөв, "Жайка" ОУБ, аймгийн Хөдөлмөр Халамж үйлчилгээний газар, ХААНТөв хамтран нийт 5 удаагийн томоохон хэмжээний сургалтыг зохион байгуулж 256 хүнийг хамруулж 300 ширхэг гарын авлага материалаар хангаж ажиллалаа.

Малчдын хамтын үйл ажиллагааг дэмжсэн сургалт явуулж, оролцооны аргад түшиглэсэн зохион байгуулалтын бүтэц байгуулахад туслах зорилгоор аймгийн ХХҮХэлтсээс сар тутам сургалт зохион байгуулж хэвшээд байна. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны дэд ерөнхийлөгч Д.Чулуунбат Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдын малчдын зөвлөгөөнд оролцож малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийг байгуулах, хамтран ажиллахын ач холбогдлын талаарх сургалт, мэдээллийг хийж, гарын авлага материал хангасан. ХХААХҮЯам, Францын Хүнсний тусламжийн хамтарсан хорооноос зарласан төслийн сонгон шалгаруулалтнаас 2 хоршоо төслийн дэмжлэг аваад байна.

Малчны бүлэг, нөхөрлөл, хоршоо зэрэг ойлголтууд хууль эрх зүйн хүрээнд бүрэн тодорхойлогдоогүй байна. Орон нутгийн түвшинд малчид хоорондоо нэгдэж бэлчээр болон байгалийн бусад нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр хамтарч байгаа ч түүнийг баталгаажуулж хуулийн этгээд болох боломж бүрдээгүй. Үүний улмаас одоогийн зохион байгуулалт нь тогтвортой бус, зөвхөн тухайн хэсэг бүлэг малчид дундын түр зуурын холбоо байдалтай байна.

Төрөөс малчдын талаар баримтлах бодлого гарсан ч малчдын зохион байгуулалтыг баталгаажуулах эрхзүйн орчин бүрдээгүй байна. Улсын хэмжээнд хичнээн малчдын бүлэг нөхөрлөл

хоршоо байгаа, тэдгээрийн үйл ажиллагааны талаар нэгдсэн судалгаа байхгүй байна. Хэрэв энэ мэдээллийн сан бүрдэж чадвал цаашдын баримтлах чиглэлийг улам боловсронгуй болгох боломжтой болно.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
<p>Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг батлуулж хэрэгжүүлэх эхний үе шатны төлөвлөгөөг Засгийн газраар батлуулсан байх</p> <p>МАА-н үйлдвэрлэлд залуу малчдыг дадлагажуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, бизнес инкубаци үйлчилгээ үзүүлэх, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. Нийт сумдын 70 хувьд нь нэвтрүүлэх нэгж бий болсон байх</p>	<p>“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 2010-2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран ажиллах 12 байгууллагаас санал авч уулзаж ярилцан аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн өргөтгөсөн хурал, ИТХТэргүүлэгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлэн боловсруулж, аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2010 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 40 тоот тогтоол гаргуулж ажиллалаа. Төлөвлөгөөг малчдын аж ахуй эрхлэх, зохион байгуулалтыг сайжруулах, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, үйлдвэрлэлийн бүтээмж, чанар, үр ашгийг дэмжих, малчдын ая тухтай ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, өөрийгөө удирдах, боловсрол мэдлэгийг дээшлүүлэх талаар гэсэн 5 бүлэг, 36 заалттай боловсруулж, малчдын талаарх суурь судалгаа, өнөөгийн байдал, төрийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж хийсэн болно.</p> <p>Аймгийн “Залуу малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж 200 малчин залууст мэдээлэл өгсөн. Мөн 5 сумын “Малчдын зөвлөгөөн”-д оролцож дэлгэрэнгүй мэдээлэл өгч, сурталчилж ажилласан. Аймгийн МАА-н мэргэжилтнүүдийн зөвлөгөөн болон сумдад үйл ажиллагаа явуулж буй МЭҮААНэгжийн захирал эзэд, сумдын ЗДТГазрын дарга нарт бүрэн эхээр нь мэдээлж ажиллалаа. Сум бүр багийн хурал, өдөрлөг зохион байгуулж малчдад мэдээлсэн. Малчдад чиглэсэн сургалтуудыг давхардсан тоогоор 22 удаа хийж 947 малчинд 1314 ширхэг гарын авлага материал тарааж хүргүүлсэн байна.</p> <p>Сум бүр багийн өдөрлөг хийж аймгийн хэмжээнд нийт 8000 гаруй малчдад сургалт мэдээлэл хийсэн.</p> <p>“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Засаг даргын 210 тоот захирамжаар салбар зөвлөл болон 11 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. 2009 онд ЖДҮ-ийг дэмжих дэд сангаас хоршооны чиглэлээр 2 хоршоонд 17 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдлоо</p>

Бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ

Хэрэгжилтийн явц

Бүтээмж өндөртэй мал, амьтдыг үржлийн чиглэлээр өсгөн бойжуулж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдийн малыг бүртгэн баталгаажуулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох зорилгоор сум бүрт цөм сүрэг бүхий өрх айлыг бий болгож, өндөр ашиг шим бүхий мал, үржилд ашиглаж буй хээлтүүлэгчийг үзлэг ангилалтанд хамруулах ажлыг жил бүр аймгийн Засаг даргын захирамж гаргуулан хийж гүйцэтгэж байна.

Гахай шувууны аж ахуйг газар тариалангийн бүс нутаг болон төв суурин газарт хөгжүүлэх, иргэн аж ахуй нэгжийг төсөл хөтөлбөрт хамруулах зорилгоор Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй Цагаан цахир уул ХХК, Түвшинтогтох ХХК-д гахай, шувууны аж ахуй эрхлэх чиглэлээр зээлийн дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаа эхлээд байна.

Махны болон сүүний үхрийн цогцолбор аж ахуйд дэмжлэг үзүүлэх төслийг сонгоншалгаруулалтад 15 иргэн аж ахуй нэгжийг дэмжиж тодорхолсноос махны үхрийн цогцолбор аж ахуй байгуулах чиглэлээр 3 аж ахуй нэгжид 650 сая төгрөгийн, сүүний үхрийн цогцолбор аж ахуй байгуулах чиглэлээр 1 аж ахуй нэгж, 1 иргэнд 38.0 сая төгрөгийн, махны хонины цогцолбор аж ахуй байгуулах чиглэлээр 1 иргэн, 2 аж ахуй нэгжид 30,0 сая төгрөгийн зээлийн дэмжлэгийг тус тус аваад байна.

ХААҮШҮОНТөв, аймгийн ХААНТөвтэй хамтран эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон фермерүүдийг оролцуулсан 121 хүнд малын зохиомол хээлтүүлэг, тэжээлийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх технологи зэрэг сэдвээр 4 удаа сургалт зохион байгуулсан. Мөн БНХАУ-ын Өмнөд, өмнөдийн хамтын ажиллагаа төсөл, Японы Жайкогийн төсөлтэй хамтран эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон цаашид уг чиглэлээр ажиллах сонирхолтой иргэдийг хамруулсан сургалтыг зохион байгууллаа. ОХУ-ын Чита мужид болсон Сибирь-Алс Дорнодын хонь, ямааны үзэсгэлэн худалдаанд Хэнтий ЦСҮАА –н захирал болон Хэрлэн, Галшар сумдын цөм сүрэг бүхий өрхийн малчдыг оролцуулж туршлага судлуллаа. Сүү, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйг аймгийн төвийн ойролцоо байгуулах зорилтын хүрээнд Хэрлэн сумын Өлзийт тосгонд “Атар Чандгана сүү” ХХК шинээр 1000 үхрийн байр барьж, БНХАУ-аас 300 толгой Хар тарлан үүлдрийн үнээ оруулж ирэн үйл ажиллагаа эхлээд байгаа ба 100 га-д эрдэнэшиш тариалж дарш бэлтгэсэн. ЖДҮ-ийг дэмжих дэд сангаас малын эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор 2009 онд 12 төсөлд 24 сая төгрөг, 2010 онд 8 төсөлд 197 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгожээ.

Хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа газрыг өмчлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох эрчимжсэн газар тариалангийн чиглэлээр хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг төсөв, татварын бодлогоор дэмжих

Хэрэгжилтийн явц

“Атрын III аян” (2008-2012), “Ногоон хувьсгал” (2005-2012), Чацаргана (2010-2021) хөтөлбөрийн хүрээнд жил бүр иргэн ААН-д дэмжлэг үзүүлж байна (Хавсралт 8).

Чацаргана хөтөлбөрийн хүрээнд оон нутагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 82 дугаар тогтоолоор баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. 2010 онд аймгийн хэмжээнд 23.6га-д нийт 30516ширхэг чацарганы суулгац тариалсан ба 2010-2012 онд нийт 55.5гад чацарганы тариалалтыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн тариалангийн гол бүс нутгуудад атаршсан талбайг эргэлтэнд оруулах зорилгоор Хэрлэн сумын Өлзийт тосгонд атаршсан 10000 га тариалангийн талбайг иргэн Баярцэцэгт, Биндэр суманд 2179га талбайг “Биндэръяа Буудай” ХХК-д нийт 12179 га талбай дуудлага худалдаагаар эзэмшүүлж аймгийн хэмжээнд 40 мянган га талбайг иргэд аж ахуйн нэгжүүд эзэмшин үйл ажиллагаа явуулж байна.

Үр тариа тариалсан талбай ба хураан авсан ургацын хэмжээ:

Үзүүлэлт	2007	2008	2009	2010
Үр тариа тариалсан нийт талбай /мян.га/	9860	2950	6776	10136,6
Хураасан нийт үр тариа /мян.тн/	2,080	2,018	10,300	7,326
1га талбайгаас авах үр тариа	5,6	6,8	13,9	8,9
Төмс тариалсан нийт талбай /мян.га/	389,2	361,5	382,3	432,6
Хураасан нийт төмс /мян.тн/	2042	2905	4614,6	4480

1га талбайгаас авах төмс	53	80	120	103
--------------------------	----	----	-----	-----

Атрын 3 дахь аян тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр тус аймагт хэрэгжиж дараах ахиц дэвшил гарсан байна. Үүнд:

- Хэнтий аймгийн газар тариалангийн салбар 2007 онд уналтад орж дөнгөж 1953 тн ургац буюу нэгжээс 2,7 цн ургац авч байсан бол 2008,2009,2010 онуудад тус салбар сэргэж нэгжээс 8-14 цн ургац авч тариалсан, уриншилсан талбайн хэмжээ эрс нэмэгдсэн.
- 2007 онтой тариалсан талбайн хэмжээг харьцуулан үзэхэд 4000 га-аар нэмэгдэж нэгжээс хураан авах ургац үр тариа 11,2 цн-ээр, төмс 40-50 цн-ээр, хүнсний ногоо 73 цн-ээртус тус нэмэгдсэн .
- Усалгаатай тариалангийн хэмжээ мөн 2007 онтой харьцуулахад 300 гаруй га-аар, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 1,5 тэр бум төгрөгөөр нэмэгдсэн.
- Тариаланч механкжуулагчдын давтан болон мэргэжлийн үнэмлэх олгох сургалтанд хамруулж нийт давхардсан тоогоор 150 гаруй хүн хамрагдсан.
- Хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж эрс нэмэгдэж гурилын 76 хувь, төмсний 100-130 хувь, хүнсний ногооний 76 хувийг хангаж байна.
- Газар тариалангийн аж ахуйн нэгжүүд бүгд мэргэжлийн аргономичтой ажиллаж байна.
- Талбайн түүхийг хөтлөж хэвшсэн.
- Малын тэжээлийн ургамал тариалах сонирхолтой аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж энэ онд 458 га-д тэжээлийн ургамал тариалж 1815 тн тэжээл хураан авсан.
- Газар тариалангийн салбарт эрхлэх аж ахуйн нэгж, ажлын байр, нэмэгдсэн.
- Техник технологийн шинэчлэл 45 хувьд хүрсэн
- Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал						
Газар тариалан фермерийн аж ахуй эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүд зээлийн дэмжлэг үзүүлэх	Газар тариалан эрхлэгч ААН, иргэнд эзэмшүүлэх талбайн хэмжээг нэмэгдүүлснээр тодорхой хэмжээний зээлд хамрагдах боломжтой болсон. Үүний дагуу 2008 онд тариалангийн аж ахуйн нэгжүүдэд 1.0 тэрбум төгрөгийн итгэлийн зээл олгосон Шалгуур үзүүлэлтийг нарийвчлах шаардлагатай.						
Байгалийн аливаа эрсдэлээс хамгаалагдсан хөдөөд тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдсэнээр хөдөөд ажиллаж амьдрах хүмүүсийн сонирхол нэмэгдэн төвлөрөл саарна	Үзүүлэлт		2006	2007	2008	2009	2010
	Сургалтад хамрагдсан хүн	Атрын III аян	-	10	15	20	29
		Ногоон хувьсгал		2710	2863	2751	1548
	Сургалтын тоо	Ногоон хувьсгал		49	61	50	44
	Шинээр нэмэгдсэн ажлын байр	Атрын III аян	-	20	25	123	250
Ногоон хувьсгал		-	-	-	30	243	
Газар тариалангийн хөгжлийг хүн амын төвлөрлийн асуудалтай шууд холбох боломжгүй тул үнэлгээ өгөх боломжгүй юм.							
Эрчимжсэн газар тариалан эрхэлж буй хувь хүн, аж ахуйн нэгжийн өсөлт, аж ахуйн нэгж, иргэдийн орлогын өсөлт	Үзүүлэлт		2006	2007	2008	2009	2010
	Усалгаатай тариалан эрхэлдэг өрх						
	Усалгаатай тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж			6	10	12	15
	Усалгаатай тариалан, га			500	524	562	608,5
	Хамгаал агдсан хөрс, м2	өвлийн хүлэмж					
Зуны хүлэмж							
нийлэг хальс			4000	5482	5520	5890	

		Нийт		4000	5482	5520	5890
		Өрхийн орлого, мян.төг					300,0
Өрхийн аж ахуйд ашиглах бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамж нэмэгдсэн байна	Газар тариалангийн зүтгэх хүчний тракторын 25%, үр тариа хураах комбайны 05%, чиргүүл дүүжин машины 15%-ийг 2008-2010 онуудад шинэчилсэн. Нийт 3 суманд төмс, хүнсний ногооны техникээр үйлчилгээ үзүүлэх дундын нэгж байгуулсан. 6 өрхийн АА эрхлэгчдэд төмс, хүнсний ногооны иж бүрдэл олгосон Суурь үзүүлэлт байхгүйгээс гадна зорилтот түвшин тодорхойгүй байна.						

Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ

Хэрэгжилтийн явц

Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх, чийгийн ууршилтыг багасгахад чиглэгдсэн нэг явалтаар 3-5 ба түүнээс илүү агротехникийн үйлдлийг гүйцэтгэх технологийн чадвартай сийрүүлүүр, урлуур, комбайн, гербицид шүршигч зэрэг нийт 204ш техникийг 2009 онд тендэрээр худалдан авч, жил бүр ургамал хамгааллын бодис ба бордоог 90% хүртэл хөнгөлөлттэй үнээр ААН, иргэдэд олгоод байна.

Тариалангийн талбайг сүрлэн хучлагатай болгон хамгаалах зорилгоор үр тариа хураах комбайн 144 ш, химийн уринш хийх 79 ш хор гербицид цацах төхөөрөмжийг 2008-2010 оны хооронд ААН, иргэний хүсэлтийг үндэслэн хуваарилан олгосон.

Хөрсний үржил шимийг хамгаалах, хог ургамалтай химийн аргаар тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хөрс боловсруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх зорилгоор 479.0 мянган литр уриншийн гербицид, 129.0 мянган литр үр тарианы гербицид, 1000 тонн эрдэс бордоог тус тус нийлүүлж хөнгөлөлттэй үнээр олгосноор нэгжээс хураан авах ургацын хэмжээ 4.0-6.3 цн-ээр нэмэгдсэн (Хүснэгт 4.7).

Усалгаатай газар тариаланг хөгжүүлж газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ

Хэрэгжилтийн явц

ХЭНТИЙ АЙМАГТ 2009, 2010 ОНД АШИГЛАЛТАНД ОРСОХ УСЛАЛТЫН СИСТЕМУУД,

№	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Шинээр барих услалтын системийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Услах талбайн хэмжээ га	Төслийн хөрөнгө оруулалт, сая, төг	Үүнээс		Ашиглалтад орсон
						Улсын төсвөөс авах дэмжлэг	Тендерг оролцогчийн гаргах хөрөнгө	
1	“ Хөлөг-Од ” ХХК	Дэлгэрхаан “ Од”	2009	200	967.1	157.0	810.1	2009.11.01
2	“ Мах экспорт ” ХХК	Хэрлэн сум “ Дээд Хэрлэн ”	2009	100	216.4	74.0	142.4	2009.11.01
3	Бор-Өндөр	“ Бор-Өндөр ”	2009	29.4	284.7	68.0	216.7	2009.11.01

	захирагчийн алба							
4	ШУТИС барилга инженер архитектурын сургууль	Цэнхэрмандал сум “Хэрлэн”	2009	10	25.3	20.0	5.3	2009.11.01
5	Иргэн Жамъяндорж	Хэсэг усны дэнж	2010	5	34,0	24,0	10,0	2010,9
6	Иргэн Амбага	Ташгайн ар	2010	5	25,0	17,0	8,0	2010,6
7	Атар Чандган сүү ХХК	Чандган	2010	75	552,6	222,6	330,0	2010,11
					339.4	1.493.6	319.0	1.174.6

Аймаг дундын отрын бүс нутагт 130 га талбайг хашиж хамгаалснаар усалгаатай хадлан, таримал тэжээл тариалах боломжтой болсон. Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 50.4 га талбайг усжуулах усалтын систем байгуулан ашиглалтад хүлээн авсан байна.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал					
Усалгаатай талбайн хэмжээг 1,0 мянган га-д хүргэнэ		2006	2007	2008	2009	2010
	Усалгаатай талбайн хэмжээ нэмэгдсэн байдлаар /мян.га/*	19.3	25.4	29.6	31.1	42.0
	Жилд нэмэгдсэн талбай /мян.га/		6.6	4.2	1.5	10.9
	Усалгаатай тариалсан талбай /мян.га/**		20.4	24.4	29.4	31.4
	Жилд шинээр барьсан ба засварласан талбай /мян.га/**		5.2	8.04	6.2	3.3

Газар тариалангийн хөгжилд биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
Үрсэлгээ бойжуулах төрөлжсөн мэргэжлийн аж ахуй байгуулагдана	Бүх сумдад Агропарк байгуулахаар шийдвэрлэж 30 тоннын багтаамжтай зоорь, 6х20 метрийн харьцаатай хүлэмж, бага оврын тракторын иж бүрдэл олгоход 142,5 сая төгрөг зарцуулсан.

Хэнтий аймгийн хэмжээнд Францын хүнсний тусламжийн хамтарсан хороотой хамтран өрхийн хүнсний хангамжийн бие даасан байдлыг сайжруулах, хөдөө, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор ХААН банкаар дамжуулан 10 иргэнд нийт 74,224,500 төгрөгийн 2 жилийн хугацаатай, хүүгүй зээлийг олгох ажлыг зохион байгууллаа. Үүнээс хүнсний ногоо тариалах зорилгоор 6 иргэн, хүнсний ногоо даршилж нөөшлөхөөр 1 ир вн, сүүний чиглэлийн үхрийн аж ахуй байгуулах өргөтгөхөөр 2 иргэн, жимс, жимсгэнэ тариалахаар 1 иргэн төслийн зээлд хамрагджээ.

Энэхүү 10 иргэн хөнгөлөлттэй зээлд хамрагдсаны үр дүнд 2010 оны 10 сарын байдлаар нийт тогтмол ажлын байр 28, түр ажлын байр 79 үүсэж эрдэнэшиш 45 тн, төмс 139,8 тн, хүнсний ногоо 15,1 тн, сүү 4 тн-ийн ургац хураан авч 96,4 сая төгрөгийн борлуулалтын орлого олжээ. Мөн нийт зээлдэгчдийн хувьд үйлдвэрлэлийн хүчин чадлаа 1,5-2,5 дахин нэмэгдүүлж, ирэх онд үйлдвэрлэл явуулах түүхий эдийн / үрийн төмс, хүнсний ногоо, тоног төхөөрөмж, сүүний үхэр гэх мэт/ нөөц, санхүүгийн боломжтой болжээ.

Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ

Хэрэгжилтийн явц

Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх, чийгийн ууршилтыг багасгахад чиглэгдсэн нэг явалтаар 3-5 ба түүнээс илүү агротехникийн үйлдлийг гүйцэтгэх технологийн чадвартай сийрүүлүүр, урлуур, комбайн, гербицид шүршигч зэрэг нийт 30 ш техникийг 2009, 2010 онд худалдан авч, жил бүр ургамал хамгааллын бодис ба бордоог 90% хүртэл хөнгөлөлттэй үнээр

мөн шатахууныг 30 %-ийн хөнгөлөлтөд аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна. Химийн уринш хийх, гербицид цацах төхөөрөмжийг 5 –ыг ААН, иргэний хүсэлтийг үндэслэн ХХААХҮЯ-наас олгуулсан Үтрэмийн аж ахуйд техникийн шинэчлэлийг хийж үр цэвэрлэх болон ачих машин 4 ш, технологийн дэвшилд нийцсэн агуулах барьж ашиглалтад оруулах зорилгоор 100 тоннын багтаамжтай 2 ширхэг босоо төмөр агуулахыг Алтан Хурх, Агро-Импекс ХХК-дад олгосон. .

Экологийн цэвэр бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

Хэрэгжилтийн явц

Экологийн цэвэр бүтээгдэхүүн (2006-2015), Иод дутлын эмгэгтэй тэмцэх III (2007-2010), Сүү хөтөлбөр (2007-2016), Чацаргана (2010-2016), Хүнсний баталгаат байдал зэрэг хөтөлбөрүүд хэрэгжиж байна (Хүснэгт 4.8).

Хүснэгт 4.8.

Стратеги зорилгод хамаарах хөтөлбөрүүдийн зарцуулсан хөрөнгө /2007-2010/

Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан хөрөнгө /сая төг/				
	2006	2007	2008	2009	2010
Экологийн цэвэр бүтээгдэхүүн		-	-	-	-
Иод дутлын эмгэгтэй тэмцэх III		-	-	-	-
Сүү хөтөлбөр		2.021	30.0	-	55.0
Чацаргана хөтөлбөр	-	-	-	-	10,5
Хүнсний баталгаат байдал	-	-	-	-	1.0

Монгол улсын ЗГ-ын 2008 оны 4 дүгээр сарын 9 ны 136 тогтоолоор батлагдсан “Агропарк” төсөл 17 суманд хэрэгжиж байна. Тус агропаркуудын үйл ажиллагааг сайжруулах, онолын болон практик мэдлэг олгох зорилгоор Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, ХААНТ-тэй хамтран зохион байгуулж үүнд агропаркийн эрхлэгч, ногоочид бүгд 30 гаруй хүн хамрагдаж мэргэжлийн үнэмлэх олгосон.

Агропаркийн хүрээнд 116,9 га-д төмс, 45,2 га-д хүнсний ногоо тариалж төмс 812 тн, хүнсний ногоо 618,1 тн-ийг тус тус хураан авсан байна.

Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж хүн амыг аюулгүй хүрэлцээтэй хүнс, тэжээлээр хангах

Хэрэгжилтийн явц

Аймгийн хэмжээгээр 49 –н аж ахуйн нэгж хүнсний үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд 202 хүртэл ажиллагчидтай байна. Монгол Улсын Засгийн газраас 2008 оныг “Хүнсний аюулгүй байдлын жил”, 2009 оныг “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил” болгон зарласнаар хүнсний салбарт 119,5 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, ажлын байр 8-ээр нэмэгдсэн байна.

Хүнсний баталгаат байдал (2009-2016) хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд аймгийн дэд хөтөлбөр, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2009 онд баталж мөн 2010 оны 02-р сард салбар зөвлөл хурлаа хийж хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

«Намрын ногоон өдрүүд» үзэсгэлэн худалдааг 2007 оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулж байна. Үзэсгэлэнд 17 сум, 5 тосгоноос жилд дунджаар 291 гаруй аж ахуйн нэгж, иргэд оролцон 100 гаруй нэр төрлийн шилдэг бүтээгдэхүүнийхээ дээжийг хэрэглэгчдэд хүргэж, 30,0-40,0 сая төгрөгийн борлуулалт хийж байна. Мөн улсын үзэсгэлэн худалдаанд жил болгон аймгийнхаа аж ахуй нэгж, иргэдийг байнга хамруулж байна.

Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд санал хүргүүлсэн болно.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
Хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд	“Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийг 2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан

хүртээмжтэй хангасан байна (ШҮ-Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт)	хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
---	------------------------------------

Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь удирдлага зохион байгуулалтын бүтцийг бий болгох, төлөвлөгөө батлах, хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан ойлгуулах зэрэг эхлэлийн шатандаа байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрчимтэй бус, удаан байна. Хөтөлбөрийн хэрэгжилт бараг эхлээгүй тул түүний үр дүнд үнэлгээ хийх боломжгүй байна.

Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний боловсруулах үйлдвэр, цехийн 96 орчим хувь нь буюу 47 үйлдвэр, цех дотоодын хяналтын лабораторигүй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ чанар аюулгүй байдлыг баталгаажуулан гаргаж чадахгүй байна. Үйлдвэрлэгч нь өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ 3 сард нэг удаа хөндлөнгийн хяналтын байгууллага болох Стандарт хэмжил зүйн хэлтэсийн лабораторийн шинжилгээнд хамруулан баталгаажуулдаг ч энэ нь үйлдвэрлэсэн цуврал бүтээгдэхүүн бүрт баталгаа болж чадахгүй байна.

5.2.3. Төрийн захиргаа, төрийн алба

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно.

Хэрэгжилтийн явц

Сумын хүн ам, газар нутгийн хэмжээ, аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо, төрийн үйлчилгээний байгууллагуудын хүчин чадлын ашиглалтын байдлыг харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын орон тооны дээд хязгаарыг²⁸ Засгийн газрын тогтоолоор баталсны дагуу аймгийн хэмжээнд сум, хот, тосгоны ЗДТГ болон ЗАА-ны орон тоог батлан мөрдүүлж байна. “Улсын тэргүүний /загвар/ сум шалгаруулах болзол”-ын дагуу²⁹ 2010 онд Өмнөдэлгэр сумыг бүсийн хэмжээнд нэр дэвшүүлэн улмаар Засгийн газрын хуралдааны шийдвэрээр тус сумыг “Улсын тэргүүний сум”-аар шалгаруулав.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
27 сумыг аймгийн төв-хоттой нэгтгэсэн байна. Аймгийн төв, эдийн засгийн бааз сайтай төвлөрсөн суурингаас 30-50 километрийн радиус дотор орших сум, суурин газрыг нэгтгэсэн тоо	Хэнтий аймгийн Баянхутаг сум аймгийн төвөөс 25 км, Мөрөн сум 27 км тус тус алслагдсан. Нэгтгэх талаар ямар нэгэн ажил хийгдээгүй байна.
Баг, хороог төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны хамгийн анхан шатны нэгжийнх нь хувьд бэхжүүлэх	“Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг 2006-2015 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2010 оныг "Багийн хөгжлийг дэмжих жил" болгон зарлаж аймгийн нийт 83 багийн дарга нарыг зургийн аппарат, сумын төвийн болон хөдөөгийн 76 багийн Засаг даргыг мотоциклоор хангалаа. Багийн төвүүдийн тохижилтонд зориулж сум бүрт 2,0 сая төгрөгийг олгоод байна. 2010 онд 9 багийн төвийг шинээр барьсан.
Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай болгон	2008 оноос боловсон хүчний босоо тогтолцоог өөрчлөн зарим агентлагийн дарга нарыг томилох, чөлөөлөх эрхийг аймаг, нийслэлийн засаг дарга нарт олгосон. 2009 оноос улсын төсөвт төвлөрдөг байсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн

²⁸ Засгийн газрын 2009,01,14-ны өдөр 13 дугаар тогтоол

²⁹ Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 193 дугаар тогтоол

хөгжүүлэх	орлогын албан татварыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх болсноор Хэнтий аймаг орон нутгийн төсөвт 5567,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, орон нутгийн зарлагаас давсан 358,5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. 2009, 2010 оны гүйцэтгэлээр орлогын өсөлт зарлагын өсөлтөөс түрүүлж , төсвийн урсгал болон нийт тэнцэл сайжирсан байна.
-----------	--

Монгол Улсын Үндсэн хуулийн 57.3-д зааснаар сум нэгтгэх асуудлыг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлж, ард иргэдийн санал асуулгаар шийдэх бөгөөд үүний тулд тухайн засаг захиргааны нэгжийг хамарсан ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах шаардлагатай. Тиймээс тодорхой орон нутгийн хэмжээнд иргэдийн саналыг хэрхэн авах, тэр нь эрх зүйн ямар үр нөлөөтэй байх тухай Ард нийтийн санал асуулгын тухай хууль /1995 он/-д өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна.

Хэрэгжилтийн явц

“Иргэний бүртгэлийн улсын нэгдсэн сүлжээ төсөл”³⁰-ийг хэрэгжүүлэн аймгийн Иргэний бүртгэлийн тасгийг Улсын бүртгэлийн мэдээллийн сантай холбов.

Цахим сүлжээнд холбогдсоноор бүртгэлийн нэгжийн мэдээлэл богино хугацаанд санд нэгтгэгдэх, солилцох болсон.

Улсын бүртгэлийн үнэ хураамжийг цэгцлэх, давхардал хийдлийг арилган нэгдсэн үнэ хураамжтай болгосон тухай Засгийн газрын тогтоолыг 2011 оны 1 сарын 1-нээс мөрдөж эхэлсэн³¹.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
"Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох" хөтөлбөрийн хэрэгжилт	Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох" хөтөлбөр ³² -ийн хүрээнд анхан шатны нэгжийн бүртгэлийн маягт, үнэт цаас, гэрчилгээг тусгай дугаараар дугаарлаж, “нэг мэдээлэл-нэг үнэт цаас-нэг бүртгэлийн маягт” системийг бүрдүүлсэн. Шифр, кодын нэгдсэн тогтолцоо, хаягийн нэгдсэн сантай болох ажлын эхлэл тавигдсан.
Цахимжсан баримт бичгийн тоо -4 сая	Иргэний бүртгэл нь цахим цаасан мэдээлэлд суурилсан хэлбэрээр хөтлөгдөж байсныг өөрчлөн орчин үеийн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд суурилсан цахим сан үүсгэж байна. Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдах ёстой 16-гаас дээш насны нийт /49280/ иргэдийн 93,2% (45938 иргэн) 2011 оны 3-р сарын 18-ны байдлаар хамрагдаад байна.
Бүртгэл мэдээллийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хууль батлагдсан байна.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг баталсан Засгийн газрын тогтоолыг мөрдөж байна ³³ .

³⁰ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэг, санхүүжилтээр /2007-2010/

³¹ “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсийг тогтоох тухай” Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 237 дугаар тогтоол

³² Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоол

³³ УИХ-ын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоол

“Монгол Улсын Иргэний шинэчилсэн бүртгэл”-ийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажил эрчимтэй явагдаж байна. Биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан иргэний бүртгэлийн шинэчилсэн цахим сан үүссэнээр “Цахим сонгууль” өгөх, “Цахим гарын үсгийн сан” үүсэх, “Иргэний ухаалаг үнэмлэх”-жүүлэх зэрэг ажлуудын эхлэл тавигдаж байна.

Төрийн албаны стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг хөгжүүлнэ

Төрийн албаны бодлогын дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэнэ

Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн болон цалин хөлс, хангамжийн тогтолцоог төгөлдөржүүлнэ.

Төрийн албаны оновчтой хэмжээг хангаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

Хэрэгжилтийн явц

Шинээр батлагдсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам³⁴”, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам³⁵” –ыг мөрдөж ажиллаж байна.

Үр дүн

2015 онд хүрэх зорилт	Өнөөгийн байдал
Нийт төсвийн байгууллагын ерөнхий менежерүүд стратегийн удирдлагын чиглэлээр сургалтад хамрагдсан байх	2007-2009 оныг дуустал хугацаанд 17 сумын 90 төсвийн байгууллагын ерөнхий менежер, Засаг даргын дэргэдэх агентлагуудын ерөнхий менежерүүдэд 3 үе шаттай сургалтыг зохион байгуулсан. 2010 онд 18 өдрийн 6 удаагийн Манлайллын ур чадварыг дээшлүүлэх сургалтад 1 сум, 3 тосгон, аймгийн төвийн агентлаг, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нийт 40 хүнийг хамруулж сертификат гардуулсан.
Нийт төсвийн байгууллагын ерөнхий менежер болон менежер /нэгжийн дарга/-үүд гүйцэтгэлийн удирдлагын чиглэлээр сургалтад хамрагдсан байх - 50 %	“Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийг удирдахуй” гарын авлагыг ашиглаж байна.
Бүх яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн ажилтнуудыг төрийн албаны бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх сургалтад хамруулж, чадавхийг нь хөгжүүлсэн байх - 50%	“Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхийг дээшлүүлэх” сургалтад давхардсан тоогоор 5 хүн, “Үр дүнд суурилсан ХШҮ-ний тогтолцоо” сургалтанд тасгийн дарга 2 удаа хамрагдсан.

³⁴ Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоол

³⁵ Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоол

<p>Төрийн байгууллага бүр “Суралцагч байгууллага” болох зорилт тавьж, олон улсын нийтлэгээр хүлээн зөвшөөрсөн “Суралцагч байгууллага”-ын шалгуурыг хангасан байна.</p>	<p>“Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сургалтад МХГ, ЭМГ болон “Тэмүүжин” цогцолбор сургуулийн захирал нар хамрагдаж сертификат авч, сургагч багшаар ажилласан. Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сургалтыг стандартын түвшинд зохион байгуулах, тэднийг татан оролцуулах зорилго бүхий Манлайллын Мастер сургагч нарын хөгжлийн семинарт 3 мастер сургагч хамрагдан энэ чиглэлийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.</p>
<p>Төрийн албан хаагчид, үүний дотор төрийн удирдах албан хаагч бүрийг хүний нөөцийн удирдлагын мэргэшүүлэх сургалтад хамруулсан байх - /50% сургалтад хамрагдана/</p>	<p>2010 онд 3 удаагийн сургалтад аймгийн ЗДТГ-ын дарга болон хүний нөөцийн мэргэжилтэн хамрагдав.</p>
<p>Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагууд ашиглахад зориулсан "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо"-ны шинэ программ хангамж, техник хангамж, сүлжээг байгуулсан байх - Бүх яам, агентлагийн хүний нөөцийн мэдээг хамарна</p>	<p>Шинэчилсэн программ хангамжийг ЗДТГ-ын хүний нөөцийн мэргэжилтний компьютерт суурилуулж, 3921 төрийн албан хаагчийн мэдээллийн бааз өгөгдлийг ашиглаж эхлээд байна.</p>
<p>Төрийн байгууллагуудаас хэрэглэгчдийн дунд санал асуулга явуулж, үр дүнг нийтэлдэг, түүний мөрөөр үйлчилгээнийхээ чанар, хүртээмжийг сайжруулдаг арга барил хэвшсэн байна</p>	<p>Сум, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ байгууллагын нээлттэй байдал, хариуцлагын түвшин, хуулийн хэрэгжилтийн байдал, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдлын талаар иргэдээс санал асуулгыг авч, мөн байгууллагын ил тод байдлын үзүүлэлтийг харгалзан дүгнэдэг болсон³⁶. Төрийн байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах нэг чухал алхам нь “НЦҮ-г байгуулах дунд хугацааны хөтөлбөр³⁷” –ийн хэрэгжилт юм. Өндөрхаан хотод НЦҮ нь 8 чиглэлээр 52 төрлийн төрийн үйлчилгээг нэг дор үзүүлж байгаа нь иргэдийн талархлыг хүлээж байна. Нэг цонхны үйлчилгээгээр 2009 онд давхардсан тоогоор 24921 иргэн үйлчлүүлж байсан бол 2010 оны эхний хагас жилд 15447 иргэн үйлчлүүлж, үйлчлүүлэгч иргэдийн тоо өссөөр байна. Үйлчлүүлэгчдээс авсан санал асуулгаар 90% нь нэг цонхны үйлчилгээний төвөөс хүссэн үйлчилгээг авч чадсан байна.</p>

Журмын³⁸ дагуу төрийн байгууллагуудаас хэрэглэгчдийн дунд санал асуулга явуулж, үр дүнгийн нэг үзүүлэлт болгож байгаа ч үйлчилгээг сайжруулахад нөлөөлж буйг үнэлэх шаардлагатай.

³⁶Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоол “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын ийл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, ир дүнг инэлэх журам”

³⁷ Засгийн газраас 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 264-р тогтоолоор баталсан

³⁸ “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын ийл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, ир дүнг инэлэх журам”

5.2. Ардчилсан засаглал

5.2.1. Хариуцлагын тогтолцоо, ил тод байдал, иргэдийн оролцоо

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг ханган, албан хаагчдыг чадавхижуулж, төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгоно.

Удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг ханган, түүнд иргэдийн оролцох боломжийг хангана..

Хэрэгжилтийн явц

Авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, төрийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах чиглэлээр 2009 оны 12 сарын 11-ний өдрийн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 103-р тогтоолоор батлуулсан аймгийн төрийн байгууллагуудын шударга ёс ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөгийг зарцуулсан.

2010 онд www.Khentii.mn аймгийн веб сайтыг бий болгож Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи мэдээллийг нэгдсэн цахим сүлжээнд байрлуулан нийтийн хүртээл болгож уг веб сайтанд “нээлттэй төр” булан ажиллуулснаар төрийн байгууллагын үйл ажиллагааны талаархи мэдээллийг олон нийт саадгүй авах боломжийг бүрдүүлсэн.

Мөн аймгийн засаг даргын захирамжаар орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулан бүх сумдын ЗДТГ болон аймгийн төрийн байгууллагууд “ил тод байдлын самбар”-тай болж түүгээрээ дамжуулан иргэдэд мэдээллээ хүргэж байна. Мөн аймгийн ЗДТГ-аас эрхлэн гаргадаг сар бүрийн “мэдээлэл” сэтгүүлээр дамжуулан аймаг, сумдын ЗДТГ, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа нийт 29 объектын барилга байгууламж барих болон засах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, 37 бараа, машин, тоног төхөөрөмж нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг “ТБОНӨХБАҮХАТ” хуулийн дагуу зохион байгуулж, тендер шалгаруулалт тус бүрийг “Өдрийн шуудан”, “Зууны мэдээ” сонин, худалдан авах ажиллагааны вэб сайт, аймгийн ЗДТГ-ын ил тод байдлын мэдээллийн самбар, “орон нутгийн мэдээлэл” сэтгүүл, www.Khentii.mn цахим хуудас, “ил тод байдлын самбар”-аар нийтэд мэдээлж нээлттэй болгосон.

Аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад мөрдөгдөж буй дүрэм журмыг нягтлан шалгах, журамлах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулан ажиллалаа. Уг ажлын хэсэг нь МХГ-ын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, УБХ, Татварын хэлтэс зэрэг байгууллагуудад ажиллаж, сумдаас төлбөр хураамж, зөвшөөрөлтэй холбоотой захирамж шийдвэрүүдийг татан авч, хянаж үзэхэд МХГазраас иргэдэд эрүүл мэндийн дэвтрийг үндэслэлгүй олгосон, ЕБС-ийн сурагчдаас үндэслэлгүй төлбөр хураамж авдаг, Хэрлэн сумын ЗДТГ-аас иргэдэд тодорхойлолт олгохдоо хураамж авдаг, УБХ-ээс үйлчилгээний төлбөр хураамжийг үндэслэлгүй нэмэгдүүлсэн зэрэг зөрчлийг илрүүлж дээрх шийдвэрүүдийг хүчингүй болгосон.

2010 оны 7-р сарын 2-ны өдөр Аймгийн Засаг даргын ивээл дор ИНБС-ний чуулган зохион байгуулж уг арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 1.5 сая төгрөг зарцууллаа. Чуулганы үеэр аймгийн Засаг дарга ИНБС-ний тэргүүний хооронд хамтран ажиллах 5 зүйл бүхий санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд шийдвэр гаргах чиглэлээр мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн байр суурийг танилцуулах, харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэн хэлэлцүүлгүүд зохион байгуулах, төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх талаар санамжид тусгасан.

Аймгийн ЗДТГ-аас төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй үйлчлэх, үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах талаархи нэмэлт өөрчлөлт оруулах загвар төслийг боловсруулж сумд болон төрийн байгууллагуудад хүргүүлсэн.

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн албан хаагчдын дагаж мөрдөх 9 зарчмыг боловсруулан АТГ-аас санал авч, Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн баталж мөрдүүлж эхэлсэн.

Төрийн албан хаагчийн эрх үүрэг, дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээний талаар гарсан хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг багтаасан “**төрийн албаны шударга байдал**” эмхэтгэлийг 2000 хувь хэвлүүлсэн бөгөөд уг эмхэтгэлд “шударга ёс миний бодлоор, шударга ёс миний нүдээр” сэдэвт зургийн уралдаан болон эссэ бичлэгийн уралдаанд шалгарсан хүүхдүүдийн бүтээлүүдийг багтаан олны хүртээл болгосон байна.

“Шударга ёс, шударга ёсыг өөрөөсөө эхэлье” сэдэвт хэлэлцүүлгийг аймгийн төвд болон бүх сумдад иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, төрийн бус байгууллагуудтай хамтран батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж давхардсан тоогоор 378 хүн, хамрагдаж зөвлөгөө авсан байна.

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газарт иргэдийг хүлээн авах өрөөтэй болж, түүнд өдөр тутмын сонин хэвлэл- Өдрийн сонин, Зууны мэдээ, Өнөөдөр, МОНЦАМЭ мэдээ, Үнэн сонинуудыг захиалан иргэдийн хүртээл болгож, шаардлагатай гарын авлага ном, Монгол улсын хуулиудын боть, бусад мэдээллээр иргэдэд үйлчилж, иргэдийн санал гомдол хүсэлт хүлээн авч харилцан мэдээлэл солилцох 23303 дугаартай утас ажиллуулж иргэдийн санал гомдол хүсэлтийг хүлээн авч, мөрөөр нь арга хэмжээ авч хариу өгч ажиллалаа. Түүнчлэн иргэдийн санал гомдол, өргөдлийг аймгийн вэб сайт, электрон шуудан, уулзалт хурал, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, санал гомдлын хайрцаг, санал асуулгын хуудсаар амаар болон бичгээр хүлээн авч ажиллах ажиллагаа тогтмолжиж хэвшив. Аймгийн ЗДТГ-т иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцгийг тунгалаг өнгөтэй болгон шинэчлэн хийж байрлуулав. Мөн энэ оноос эхлэн аймгийн ЗДТГ-т албан хэрэг хөтлөлтийн цахим программыг нэвтрүүлж, ирсэн албан бичиг, санал өргөдөл гомдлыг цахим санд бүртгэн өдөр бүр хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан байна.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлан мэдээгээр хуулийн үйлчлэлд хамрагдаж хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих нийт 416 албан тушаалтнууд 100% хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлсэн байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ТАСГИЙН ДАРГА

Д.ГАНБОЛД